Дагалдан гарсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 5.Ирээдүйн өв сангийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна. 6.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 8.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулга сонссонд тооцлоо. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Гаалийн албан татварын татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр санал гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр



саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

12.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 13.Гаалийн албан татвараас татварыг хөнгөлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр санал хийх юм байна уу, алга, эцсийн найруулга сонссонд тооцлоо. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 18.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 19.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

20.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төрийн, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар БЗД-ийн ерөнхий боловсролын 60, 69 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хэлэн ерөөе. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга

байна, сонслоо. 29.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо.

30.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 36.Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 38.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. 39.Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга

дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт



оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тамхины тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулагыг сонссонд тооцлоо. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Малын хулгай, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Таримал ургамлын үр сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

60. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Мансууруулах эм, сэтгээд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 68. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт орох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулга дээр саналтай гишүүн байна уу, саналтай гишүүн алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хүн худалдаалах гэмт хэрэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. 79.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

80.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо эцсийн найруулгыг. 81.Соёлын

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Аялал жуулчлалын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Онцгой албан

татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

100.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, сонссонд тооцлоо.

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зочид танилцуулъя МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Орчин үед бол шинжлэх ухаан салбар дундын шинж чанартай болж байгаа. Улс төр эдийн засаг, улс төр хууль, улс төр философи гээд одоо улс төрийн шинжлэх ухаан бол нэн ялангуяа энэ хуулийн шинжлэх ухаан ч гэсэн салбар дундын шинж чанартай интердисциплинар буюу. Тийм учраас энэ шинжлэх ухааны шүтэн барилдлага буюу салбар дундын судлалыг сайн хөгжүүлэх шаардлага бол байна. Улс төрийн эрхэм зорилго бол ард түмнээ амгалан тайван, сайн сайхан амьдруулах, элбэг хангалуун амьдруулах явдал гэж томъёолдог юм. Тийм учраас сурах чиглэлийг хандвал эрхэм зорилго хандах зүг чинь өөрөө тогтоно, сайн сурицаагаарай гэж хүсэн ерөөе гишүүдийн нэрийн өмнөөс.

Ингээд төсөв дагаж батлагдсан тогтоолууд үндсэндээ ингээд батлагдаж дуусаж байна. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 107.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах арга хэмжээний тухай авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төсвийн тухай холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүд байгаа. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Нэгдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 112. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дагалдан гарсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга

байна. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 10. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна, эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонслоо.

10.40 цаг



Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаанд зарлан мэдээлэхээр Дэгийн тухай хуулийн 19.1-д орсон өөрчлөлтөөр тусгасан юм байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо, хороо хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол холбогдох болон бусад Байнгын хороог зөвлөлтэй зөвшилцөн тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг танилцуулъя. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Лхагвын Мөнхбаатар, Жадамбын Бат-Эрдэнэ нар 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан байна.

Газрын тухай багц хуулиудыг хууль санаачлагч байхгүйгээс хойшлуулсан учраас өнөөдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан байна. Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан завсарлаж байна. Одоо 13 цагаас Даргын дэргэдэх зөвлөлийн хурал хуралдана. Ирэх 7 хоногийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэх асуудлын тов дарааллыг батална. Үдээс хойш 14 цагаас намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулууны мэдээллийг сонсоно. Болорчулуун сайд хаачив, энд байсан. Дуудчих.

Ингээд үдээс өмнөх хуралдаан завсарлалаа.

10.42 цагт

2022 оны 11 дүгээр сарын 18, Баасан гараг,  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 00 минут.

### **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Улсын Их Хурлын намрын чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

**Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/**

Үдээс хойших хуралдаанаар Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга, арга хэмжээний талаар ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулууны мэдээллийг сонсоно. Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлэх ёстой. Цөөнх асуулт асууна, цөөнхийн гишүүд. Тийм учраас ажлын хэсгийг оруулъя. Эндээс ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун мэдээлэл хийнэ. Индэр урьж байна.

**Х.Болорчулуун:** Намрын ургац хураалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлээр авч

хэрэгжүүлж буй арга хэмжээний танилцуулга.

1. Ургац хураалтын урьдчилсан ургац хураалтын дүн, авч хэрэгжүүлсэн ажлын талаар. Энэ онд улсын хэмжээнд 353.4 мянган гад үр тариа, үүнээс 329.1 мянган гад улаан буудай, 19.9 мянган гад төмс, 11 мянган гад хүнсний ногоо, 67.9 мянган га малын тэжээл, 115.2 мянган гад тосны ургамал, 4.6 мянган гал жимс жимсгэнэ, нийтдээ 567 мянган га тариалалт хийсэн. Ургац хураалтын ерөнхий дүнгээр 408.6 мянган тонн үр тариа хураан авлаа. 210.7 мянган тонн төмс, 137.4 мянган тонн хүнсний ногоо, 161.7 мянган тонн тэжээлийн ургамал, 42.7 мянган тонн тосны ургамал хураан авлаа.

Ургацын дүн өнгөрсөн жилтэй харьцуулахад төмс, хүнсний ногооны ургац тус бүр 15 хувиар нэмэгдсэн байна. Одоогийн байдлаар энэ оны ургацаас гурилын үйлдвэрүүд 150000 тонн, ХАА-г дэмжих сан, стратегийн хүнсний нөөцөд 25000 тонн улаан буудай авч, гурил үйлдвэрлэлд нийт 175000 тонн хүсний улаан буудай одоогийн байдлаар нийлүүлэгдээд байна. Тариалан бүхий ААН, иргэд дараа оны тариалалтад зориулан 49000 тонн үрийн улаан буудай нөөцлөхийн зэрэгцээ тэжээл 79000 тонн, спиртийн үйлдвэрт 15000 тонн буудай нийлүүлсэн, тариалан ААН нэгжүүдийн агуулахад 70000 тонн улаан буудай одоогоор борлогдоогүй байна. Цаг агаарын төлөв байдалтай уялдуулан ургац хураалтын ажлыг богино хугацаанд шуурхай зохион байгуулах, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангах зорилгоор сайдын зүгээс Улсын ургацын комисс, холбогдох мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлагуудад албан даалгавар, үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг ханган зохион байгууллаа.

Ургац хураалтыг технологийн хугацаанд зохион байгуулах талаар дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд цогц төлөвлөгөөний хүрээнд 1445 иргэн, ААН-д 3 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, 103 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэн, тариалалт, урини боловсруулалт, ургац хураалтын ажлуудыг агро техникийн хугацаанд явууллаа.

Төмс, хүнсний ногооны 1871 га, малын тэжээлийн 5000 га, жимс, жимсгэнэ 1450 га, мод үржүүлгийн газар 1450 га талбайг шинээр нэмэгдүүлж, ХАА-г дэмжих сангаас улаан буудайн 10.3 мянган тонн үрийг 263 ААН, иргэнд 30 хувийн урьдчилгаатай зээлээр, хүнсний ногооны 48 тонн үрийг 113 ААН, иргэнд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор намрын ногоон өдрүүд 2022 нэгдсэн арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг нийслэл болон аймгийн төвүүдэд зохион байгуулахын зэрэгцээ Улаанбаатар хотын Захирагчийн албатай хамтран 9 дүүргийн 31 байриилд томоохон хэмжээний хүнсний ногоо борлуулах төвлөрсөн цэг байгуулан ажиллуулсны үр дүнд 5000 тонн төмс, хүнсний ногоог худалдан борлуулсан байна.

Улсын хэмжээнд 254000 тонн багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорь, агуулах, үр тариа хадгалах 550000 тонны багтаамжтай төмөр болон бетон элеватор байгаагаас ХАА-г дэмжих санд 186000 тонн, хувийн хэвшилд 364000 тонн ашиглаж байгаа бөгөөд агуулах зоорь элеваторуудын ариутгал, засвар үйлчилгээ хийж, шинэ ургацыг хүлээж авсан болно.

Засгийн газрын 2022 оны 276 тогтоолын дагуу ургацад ажиллах хүн хүчний захиалга, судалгаа гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулснаар 5 их, дээд сургууль, Зэвсэгт хүчний Жанжин штабын 18 анги нэгтгэлээс нийт 3100 оюутан сонсогч, цэргийн албан хаагчид ургац хураалтад оролцсон юм. Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах

зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 36 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд газар тариалангийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулаад байна.

Хоёрт өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлыг хангах талаар. ХАА-н салбарын 2022-оос 23 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 277 дугаар тогтоол, 22-23 оны өвөлжилт, хаваржилтийн болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 09 дүгээр албан даалгаврыг орон нутагт хүргүүлснээр Засаг дарга нар захирамж гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Энэ жил улсын хэмжээнд 188000 малчин өрхөд 71.2 сая хонин толгойд иилжүүлснээр 122.5 сая толгой мал өвөлжиж, 19.9 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулах урьдчилсан дүн гараад байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар зөвлөмжөөр үхрийн мах, түүхий мах 8000 тонн, дулааны аргаар боловсруулсан үхрийн мах 5000 тонныг, харин адуу, хонь, ямаа, түүхий болон дулааны аргаар боловсруулсан махыг бодлогын хэмжээнд хүнсэнд хязгаарлалтгүй экспортлохоор баталсны дагуу БНХАУ руу дулааны аргаар боловсруулах мах, мах, махан бүтээгдэхүүн, баруун аймгуудаас Казахстан, Иран улсуудад адууны махны экспорт хийгдэж байна. 2022 оны 11 сарын 17-ны байдлаар адууны мах 2.9 мянган тонн, хонь, ямааны түүхий мах 3.4 мянган тонн, нийтдээ 6.3 мянган тонн мах экспортлоод байна.

Хот суурин газрын хүн амын хаврын махны нөөцийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 174 дүгээр тогтоолоор 1 жилийн

хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй, 130 тэрбум төгрөгийн зээлийн нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч ААН-үүд олгохоор шийдвэрлэсэн дагуу 22 оны 11 сарын 10-ны өдрийн байдлаар мах бэлтгэгч 4 ААН-д Хаан, ХХБ-аар дамжуулан 46 тэрбум төгрөгийн зээл олголоо. Түүнчлэн аймгуудын мэдээллээр 2.5 мянган тонн мах, нөөц нөөцлөхөд зориулж 1.1 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Нийт малчин өрхийн 11.5 хувь буюу 21.8 мянган өрх нийт өвөлжих малын 13.3 хувь буюу 9.5 сая мал отроор өвөлжиж, хаваржих бэлтгэл хангагдлаа. Отроор өвөлжих малчин өрх, малын тоо энэ бэлчээрийн даацтай уялдан өмнөх оныхоос 2.2 мянган малчин өрх 1.1 сая малаар өссөн байна. Энэ жил 9 аймагт 599000 гад хадлан бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлснээр малчдын түвшинд 1.1 сая тонн сүрэл, 15000 тонн ногоон тэжээл, 88000 тонн үйлдвэрийн тэжээл, 32.4 мянган тонн гар тэжээл, 47.9 мянган тонн дарш, 13.1 мянган тонн хужир шүү, 92.2 мянган тонн. Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 21000 тонн, тэжээл 8.2 мянган тонныг бэлтгэснээр өмнөх оноос 30 хувиар нэмэгдсэн байна.

Түүнчлэн мал сүргийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 онд нийт 11.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 540 инженерийн хийцтэй худаг, малчид өөрийн өргөөр 165 худаг гаргах гаргаснаар 975 мянган га бэлчээр, 3195 малчин өрх, 1.7 сая мал усаар хангах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Мөн энэ онд бодын 1542, богийн 3133 хашаа, саравч шинээр барьж, улсын хэмжээнд бодын 89.4 мянган хашаа, богийн 158 мянган хашаатай болохоор хашааны хангамж 97.6 хувьд хүрсэн.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд энэ жилийн төлөвлөгөөт тарилга, туулгалт, ариутгал халдваргүйтэл тандалт шинжилгээ 84-95 гаруй хувьтай дуусаж, шүлхий өвчин өвчний зургаан сая тун, үхрийн арьсны товруутах өвчний 500000



тун, хонины цэцэг өвчний 462.8 мянган тун вакцины нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангалаа. Өнөөдрийн байдлаар малын гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчнөөр тайван болоод байна. Харин хонины цэцэг өвчин 10 сарын 10-наас хойш өвчлөл бүртгэгдээгүй бөгөөд бог малын мялзан өвчин Архангай, Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Төв, Дорноговь зэрэг 7 аймгийн 15 сумын 22 голомтод хорио цээрийн дэглэмийг тогтоон тэмцэх ажиллах арга хэмжээ хэрэгжүүлж байна. МАА-н салбарын өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтээр дүгнэхээр улсын хэмжээнд 87.4 хувьтай бэлтгэл хангагдсаныг танилцуулж байна.

МАА-Н салбарын өвөлжилт хаваржилтийн бэлтгэл болон байдлыг хангаж байгаа хэдийч уншлага тааруу байсан нутгийн баруун хэсэг, говийн аймгуудын нутгаар зудын эрсдэл өндөр байна. УОК шуурхай бүлгийн хийсэн гамшигийн эрсдэлийн үнэлгээгээр Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Увс, Ховд, Өмнөговь аймгууд эрсдэл их, Архангай, Говь-Алтай, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгууд эрсдэл дунд зэрэглэлтэй гарснаар сумын нийт дүнгээр авч үзвэл 11 аймгийн 82 сум их эрсдэлтэй, 82 сум дунд эрсдэлтэй дүгнэгдлээ. Тиймээс цаг агаарын хүндрэл бэрхшээл, хариу арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалтыг улам сайжруулах, отрын маргаангүй гаргахгүй байх, зам, давааг байнга нээлттэй байлгах, хүнс тэжээл, шатахууны нөөцийг тогтмол байлгах, цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээллийг сум, баг, малчдад шуурхай хүргэх зэрэг үүрэг чиглэлийг бүх шатны Засаг дарга нарт өгөөд байна. Цаашид тогтвортой ХАА-н зориулалтын хүрээнд малчин тариаланчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, эрчимжсэн МАА-н болон усалгаатай тариаланг

хөгжүүлэх, хөрсний үр шимийг хамгаалах, сайжруулах, бэлчээр тариалангийн талбайг хамгаалах, тээвэр ложистик, худалдааны эргэлтийг сайжруулах чиглэлээр эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэхэд онцгой анхаарч та бүхэнтэй хамтран ажиллах болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ. Индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид мянга мянган жил бэлчээрийн сайныг даган нүүдэллэж, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, ган зудаас бүрэн шалтгаалан байгалийн эрхшээлээр аж төрсөөр ирсэн. Хүн төрөлхтөн аж үйлдвэрийн хувьсгал, автомат робот, сансар эрхсийг эзлэн суурьших тухай ярьж өрсөлдөж байна. Харин бид аанаа л дундад зууны үеийнх шигээ өнөө өвлийг хэрхэн давах вэ, цас битгий ороосой, цас бага ороосой, бага хүйтрээсэй, тэнгэр хангай ивээж үзээсэй гэж ард иргэд, төр засгийн ялгаагүй алга хавсран залбирахаас өөр шийдэлгүй байна.

Хариуцсан яам нь хариуцсан яамны чаддаг ажил нь өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил гэж бэлтгэсэн өвс, тэжээлийн мэдээ цуглуулж шивэх, цаг хүндэрвэл хэдэн прес өвс, онцгой фондоос аваачиж өгөх их сайндаа улаан буудай, импортын тэжээлийн НӨАТ-н татвар, гаалийн татварыг чөлөөлөх, санал оруулах төдийхөн. Ярьдаг сэдэв нь өнөө өвлийг яаж хохирол багатай давах вэ л гэж ярихаас биш 10 жил битгий хэл, 3 жилийн дараах бодлогын асуудлууд, экспорт, хөдөлмөрийн төрөлжилт, тариаланчдын орлого, малын түүхий

эдийн боловсруулалт зэрэг асуудлууд орхигдсоор удлаа. Жинхэнэ тэр зуд чинь малчны хотонд биш, тэр ХХААЯ, жинхэнэ тэр ган чинь тариан талбайд биш Засгийн газрын хөдөөгийн хөгжлийн бодлогод байна. Өвөл хүнд, малаа яах вэ, намар хүйтэнд будаагаа будаагаа хэрхэх вэ гэж сандралддаг мөртөө малчдын орлого, орлого бүтээмж, тариаланчдын амьжиргааг таг мартаад өчнөөн жил боллоо.

Тэтгэврийн насыг наашлуулна, шимтгэлийг нь төлүүлнэ гэх мэтээр шилний цаанаас чихэр долоолгосон сонгуулийн саналыг нь авахад анхаарснаас биш, орлогыг нь өсгөх, амьдралын хэв маягийг нь орчин үежүүлэх, хүн төрөлхтний хөгжилтэй хөл нийлүүлэн алхуулах ямар бодлого, шийдлийг Монголын төр өнгөрсөн хугацаанд гаргасан бэ? Уг нь малаас урьтаж малчнаа, тарианаас өмнө тариаланчдынхаа асуудлыг ярих ёстой. Монгол хүн, Монголын иргэд баян, эрүүл, тав тухтай, ирээдүйдээ итгэлтэй, эдийн засгийн баталгаатай аж төрөн суухын тулд мал маллаж, тариа тарьж байгаа болохоос биш хотынхныг хямд мах хүнсээр хангахад зориулагдсан хүмүүс биш. Өвөлжилт, хаваржилтад зөвхөн мал хүндэрдэг юм биш. Малчид, тариаланчид мал, ургацаасаа илүүтэй зутардаг. Ийм учраас залуус нь халишрч, охидууд нь зугтаж, хөдөөд хүйсийн тэнцвэр алдагдаж, Монголын ирээдүй маргааш, Монголын ирээдүй маргаашид аюулын харанга дэлдсээр байна.

Хүнээ мартаж, мал буудайг лчухалчилсан тэр мангар бодлого эцэс болох ёстой. Өнөөдрийг аргалсан, нэг өвлийг аргацаасан ийм бодлогыг цаашид үргэлжлүүлэх аваас зөвхөн малчид, тариаланчдын ирээдүйгээр зогсохгүй Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул үүсэх нөхцөл байдал үүсэж байна. Монголын ХАА-н салбарт эртнээс, эртнээс эдүгээг хүртэлх бидний түүх, үндэсний ялгарал, ёс заншлыг тээсээр ирсэн ийм онцлогтой салбар. Энэ онцлог,

ялгаа нь хадгалагдан, орчин үежүүлэх бодлогыг эрх баригч та бүхний үе үеийн Засгийн газар даанч хэрэгжүүлсэнгүй. Ахиад сануулахад Монголын ХАА-д энэ өвлийг яах вэ гэсэн аргацаасан бодлого биш, малчид, тариаланчдын орлого, амьжиргаа явал дээшлэх вэ гэдэг улсаараа хэрхэн урагшлах вэ гэдэг хувьсгалт өөрчлөлт энэ салбарт хүлээгдэж байна.

ДНБ-ий 10 гаруй хувийг бүрдүүлдэг, нийт өрхүүдийн хорь гаруй хувийг эзэлдэг малчид, тариаланчдын амьдрал ахуй өдөр өдрөөр уруудан доройтож, өөрчлөлт шинэчлэлээс хоцорсоор байна. Зүүн баруун аймаггүй улс даяараа малын халдварт өвчин тархаж, урагшгүй бодлогын үрээр жил дараалан тариаланчид буудайгаа борлуулж чадахгүй нөхцөлд хүрч, хүнсний хангамж, аюулгүй байдал байдал, эрүүл хүнс, экспортын боломжууд ч аль хэдийн орхигдлоо. МАА-д ч, газар тариаланд ч элдэв янзын татаас, урамшууллыг өгч аргалахаас өөрөөр ажил хэрэг, бодлого яригдсангүй. ХАА-н салбарт татаас, дэмжлэг туслалцаа байх ёстой. Гэхдээ энэ нь богино хугацаанд хүчтэй дэмжлэг үзүүлж, хөл дээр нь босгоод бие даахад нь тусалдаг схем байх ёстой. Тэрнээс биш өнөөгийнх шиг амыг нь хаахад чиглэсэн, өсөж хөгжихөд чөдөр тушаа болсон, санал авах төдийхөнд чиглэсэн ийм хэлбэрээр биш.

Дэлхий дээр ганцхан Монгол нүүдлийн МАА-тай учраас экспортлоход гарал үүслийг тогтооход стандартыг нь хангуулахад амаргүй байна гэх үлгэрийг бид 30 жил бие биедээ ярьсан. Ухаад үзвэл Америк, Аргентин, Бразилд хүртэл нүүдлийн МАА байна. Манайх шиг зөвхөн нүүдлийн аж ахуйтай Айсланд гэхэд л МАА, ХАА нь хөгжиж, хөршүүддээ экспорт хийж, эдийн засгаа чирч ажиллаж байна, амьдарч байна. Болохгүй бүтэхгүй, байхгүй гэсэн сэтгэлгээ, ойлголт, түүнээс улбаатай аргацаасан бодлого л Монголын ХАА-н салбарын хөгжлийн боломжийг хааж

байна. Иймдээ ч өнөөг хүртэл малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн систем тогтолцоогүй, яг дундаж зуунаараа. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гэдэг бол салбарын бодлогыг зохицуулах ёстой газар. Гэтэл өнөөдөр уг салбарын гэтэл уг яам нь энэ салбарынхаа хамгийн том тоглогч, бизнесмен болчихоод байж байна. Бордоо, ургамлын хамгааллын бодис нийлүүлдэг, үр нийлүүлдэг техник оруулж ирж зардаг, зээл олгодог бүтээгдэхүүн худалдаж авдаг гээд хийхгүй бизнес энэ яаманд алга.

Татвар төлөгчдийн мөнгөөр татвар төлөгчидтэйгөө өрсөлдөж үзэлцэх хэр нь татаас хөнгөлөлтийг тасралтгүй өгөх мөртөө өр зээлдээ баригдсан, төсвийн мөнгийг гамгүй үрсэн сангуудтай тийм том мангас болчихоод байна. Үүнийгээ өөрчилж, салбарыг төрийн хяналт оролцооноос яаралтай чөлөөлж, бодлогын дэмжлэг үзүүлж, экспортод зарахгүй бол ХАА-н салбарт нүүрлэсэн ган, зуд, гамшиг ахиад цаашаа үргэлжилнэ. ХАА-н салбарын үндсэн бүтээгдэхүүн хүнс. Хүнс үйлдвэрлэнэ гэдэг алхам тутамдаа стандартыг сахиулах ёстой. Стандартыг нь хангавал нүүдлийн байна уу, эрчимжсэн байна уу гэдгээс үл хамаараад экспорт хийх боломж дэлхий даяар байна. Гэтэл экспорт хийж чадахгүй байгаагийн хамгийн том шалтгаан нь вакцинтай мах, антибиотик, химийн үлдэгдэлтэй сүү, сүү, хүнсний ногоо, цоорхой арьс. Үүнийг өөрчлөх, сайжруулах, стандартыг нутагшуулах, мөрдүүлэх чиглэлд өдийг хүртэл хариуцсан яам нь яг юу хийсэн юм бэ, ямар ахиц гарав гэдгийг өөрсдөөсөө бас нэг асууцаая.

Өнгөрсөн нийгмийн үед өр зээл тавин байж улсаараа хөдөлнө, атар газар эзэмшинэ, малыг нийгэмчлэн нэгдэлжих гэсэн оролдлогыг хийсэн. Зах зээлийн харилцаанаас хол, хэрэглэгчийн хүсэл сонирхолд тулгуурлаагүй, оролцогч талуудын сонирхлыг тус тусгаагүй тул бүх шийдэл амжилт ололгүй нуран

унасныг бид нар бүгдээрээ мэднэ. Үүнээс хойш буруу зөв нь хамаагүй, бодлогын шинэчлэлт, өөрчлөлтийг өөрчлөлтийн шинжтэй ямар ч ажил хийгдсэнгүй. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 20 жил, 20 жилийн өмнө нийт экспортын жар орчим хувийг бүрдүүлж байжээ. Өнөөдөр 10 хүрэхгүй хувь болж ажиж, жижгирсэн. Энэ бол эрх баригчид та бүхний амрыг нь бодож ухааж ачаад урагш хил гаргаад асгадаг нүүрсийг чухалчилсан бодлогын л үр дүн.

Уг нь малын түүхий эд, мах, сүү, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулсан бүтээгдэхүүнийг экспортыг дэмжих зөв бодлогыг хэрэгжүүлсэн бол ард нь ажлын байр, ахиуц нэмүү өртөг ихээр өсөж, улс орны эдийн засагт оруулах хувь нэмэр, хувь нэмэр хүртээмж хавь илүү байсныг байсан байх нь дамжиггүй. ХАА-н салбарт хэрэгжүүлэх бодлого, алдаагаа олж, оношоо зөв тавихаас эхлэх ёстой. Капиталист эдийн засаг, масс үйлдвэрлэл, төвлөрлийг илүү шаарддаг. Энэ нь бусдаасаа хол, бэлчээр дагаж нүүдэллэдэг, нүүдлийн МАА-тай огтлолцдоггүй. Ийм ч учраас энэ ялгааг нь ойлгож, үндэсний онцлог, соёлын ялгаа дээр тулгуурласан өвөрмөц бүтээгдэхүүнийг хөгжүүлж, төрөлжүүлэх шаардлага байгаа ч төр засгийн зүгээс юу ч хийгдсэнгүй.

Газар нутгийн онцлог, бүтээгдэхүүн боловсруулах уламжлалт арга ажиллагаанд тулгуурлаж, айргийн сарлагийн ямааны зэрэг эдийн засгийн бүс кластерууд үүсэх боломжтой. Үүний тулд үйлдвэрлэлийн технологи боловсруулалт, савлагаа, тээвэр ложистик, өртгийн сүлжээний бүх шаардлагад тавих шаардлага, стандартыг тодорхой зааж өгч хэвшүүлэхэд анхаарах ёстой. Үүн дээр санаачилга, гүйцэтгэл дутагдаж байгаагаас биш хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт хийгдэхгүй байна. Энэ стандарт шаардлагаар дамжиж хөдөлмөр төрөлжиж,

бүтээгдэхүүн ялгарч, бүтээмж өсөх болно. Үр дүнд нь хэлцлийн зардал, transaction cost буурах, зах зээлд оролцогч талуудын тоо олиширч, өртөг нь буурч, оролцогч талуудын хэн хэн нь хожно.

Дэлхий нийт органик хүнс, цэвэр байгалийн бүтээгдэхүүнүүд рүү хошуурсаар. Гэтэл бид байгалийн гаралтай малын мах, сүү, түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнээ ямар үнээр аль нутаг руу борлуулж байгаа билээ. Борлуулах, боловсруулах биш, ихэнх нь хаягдал болж үлддэг боллоо. Амаараа бол бид нар органик эрүүл хүнсний тухай улс төрчид олон жил ярьсан. Ахиц болгосон ахицтай шийдэл харин байхгүй. Услалтын систем, дуслын услалт, вертикал фарм, уриншгүй элдэвшиүүлэлт, гарал үүслийн мөшигх тогтолцоо зэрэг энэ салбарын технологи дэлхий дахинд урагшилсаар байна. Өвлийг өнөтэй авахаар тал талдаа хичээцгээх нь зүйн хэрэг. Өнөтэй ч сайхан өвөл болоосой гэж үүнд тал талаас анхааран бэлдээсэй гэж бид ч бас хүсэж байна.

Гэвч нэг өвлийг аргалдаг, дараагийн өвөлд яахаа мэдэхгүй мөрөө хавчин аль болох аж төрөх вэ. Энэ өвлийг эсэн мэнд давлаа ч дараагийн өвөл хүлээж эрс шинэчлэл, өөрчлөлтүүд хийгдэхгүй бол 5, 10, 50 жилд ч ийм л байна. Энэ бүхэн бол өдийг хүртэл ЗГ ХАА-н талаар бодлого баримтлах бодлого, стратегиа тодорхойлоогүй нь л гай. Бодлого гэхээр ган зуд, гамшиг, осол, өвөлжилт, хаваржилт гэх мэт цаг зуурын цаг зуурын хүндрэлийг ярьдаг байдлаасаа болих цаг ирсэн. Монголын ХАА-д цаашид тооны их рүү зорьж зуун сая мал, сая эргэлтийн талбай эзэмших чиглэлд явах юм уу, аль эсвэл бүтээмж ихтэй, өрсөлдөх чадвартай тариалалт мал маллагаа руу орох ёстой юу. Хөгжих, хөгжих дэвших боломж дүүрэн, онцлог ялгарал, уламжлалаар баялаг Монголын ХАА-н салбарыг төрийн үрэлгэн данхар савраас чөлөөлж, экспортод зорьдог, эрүүл стандарттай бүтээгдэхүүнтэй,

орлого ашигтай, өвлөөс айдаггүй, залуус нь тэмүүлж очдог, сэтгэл хангалуун аж төрдөг төрдөг ийм бизнес, аж ахуй болгох бодлого чиглэлийг нэн даруй гаргахыг бас эрх баригчид та бүхнээс бас хүсэж байна.

Оносон бодлогогүй, төлөвлөсөн хараагүйгээр хүчээ нэгтгэхгүй бол юу болдгийг ойрын хэдэн жилийн үйл явдлууд та бүхэнд хангалттай харуулж байна, одоо зогсоё. Төрийн бүх эрх мэдлийг хянаж буй эрх баригч та бүхэн хүчээ биш бодлогоо нэгтгэхэд анхаарахыг хүсье. Төр бүх түвшинд бодлогоо нэгтгэсэн цагт хүссэн ч, эс хүссэн ч ардын хүч тэнд нэгтгэгдэх болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, ХХААХҮ-ийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, ХХААХҮ-ийн яамны Газар тариалангийн бодлого хэрэглэлтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, тус яамны Үндэсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, ХХААХҮ-ийн яамны Малын генетикийн нөөцийн хэлтсийн дарга Даваасүрэнгийн Батсүрэн, Малын эмнэлгийн ерөнхий газрын дарга Дамдинжавын Батчулуун нар байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Мэдээлэлтэй холбогдуулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх, цөөнхийн гишүүдийг бүртгэж, асуулт асуулгана. Наянтайн Ганибал гишүүн асуулт асууя, асуулт асууж, үг хэлнэ.

**Н.Ганибал:** Өвөлжилтийн энэ мэдээлэлтэй танилцлаа. Сая манай бүлгийн дарга ч бас маш тодорхой, онцгой сайхан хэллээ. Ер нь бид нарт одоо шинэчлэлийн реформууд бол



зайлиггүй хэрэгтэй байгаа. Уламжлалт энэ сэтгэлгээнээсээ салах ХАА-н салбар зайлиггүй шаардлагатай байгаа. Саяхан 20 сая, 30 сая, 40 сая гээд 10 жилийн өмнө 40 сая байсан мал өнөөдөр 70 сая болсон. Тэгэхээр бодлого өөрчлөгдөх ёстой. Өөрчлөгдөх, өөрчлөгдөхдөө нэлээн томоохон өөрчлөлт зайлиггүй шаардлагатай байгааг өнөөдөр манай хөдөө амьдарч байгаа малчдын маань амьдрал бэлээхэн харуулж байна.

Өнөөдөр Хөдөө аж ахуйн яам маань малчид жилд сардаа хэдэн төгрөгийн орлого олж байгаа талаар ер нь бодож байна уу? Тэнд хүмүүс хувийнхаа бизнесийг хийж байгаа. Гэхдээ тэнд олж байгаа орлого нь амьдралд хүрч байна уу, үгүй юу гэдэг бол энэ салбарын бодлого байх ёстой. Тэгэхээр энэ дээр бас хэд хэдэн асуулт байна. ХАА, МАА дээр, мөн газар тариалан дээр. Манай газар тариалангийн салбар дэлхий дээр байдаг бүхий л хөнгөлөлтийг авдаг. Тэнд урамшуулал авдаг уу авдаг, тарифын хөнгөлөлт авдаг уу авдаг, импортын тарифын бас дэмжлэг авдаг уу авдаг, хөнгөлөлттэй зээлүүдийг авдаг уу авдаг. Харамсалтай нь өнөөдөр Монголчууд нийтээрээ хамгийн үнэтэй гурилыг идээд сууж байгаа. Энэ бодлого мөн үү? Өнөөдрийн энэ салбарын өмнө тулгамдсан өвөлжилтийн асуудлууд гээд ингээд тавигдсан байна л даа мэдээллийн төгсгөлд.

Хөдөө орон нутагт дизель түлш олдохоо байгаад 4, 5 хонож байгааг ер нь манай ХАА-н сайд маань мэдэж байгаа юу. Энэ ЗГ-ын хуралдаан дээр яригдсан уу? Нэн ялангуяа зүүн бүс өнөөдөр цас орж байна, намаржаанаасаа өвөлжөө руугаа малчид явах гээд шатахууны хомсдолд орчхоод нүүж чадахгүй байна. Хадсан хэдэн өвсөө хот рүү оруулж борлуулах гээд тээврийн түлш олдохгүй байна. Магадгүй тав хоногийн дараа Улаанбаатарт махны үнэ өснө, тэр махыг зөөдөг тээврийн хэрэгслийн бүгд дизель түлшээр явж байгаа. Тэрийгээ тооцсон уу? Энэ асуудлууд өдөр тутамд

том бэрхиээл, сорилтууд гарч ирээд байна. Одоо махны экспорт харьцангуй бас нэмэгдэх хандлагатай байгаа. Энэ дээр бас болж байгаа, бас хийж байгаа, сэтгэж байгаа сэтгэлгээнүүд чинь болж байгаа гэж бодож байна. Гэхдээ энэ асуудлууд дээр тийм нэг 2 үзүүртэй зүү шиг асуудалд ханддагаа одоо аль, аль ЗГ болимоор байна. Махыг жооохон бэлдээд гаргаад эхлэхээр Улаанбаатарт махны үнэ өсчихлөө гээд шууд ЗГ нь тэр татварыг нэмдэг. Нэг эсвэл гаалийнхаа хаадаг, гаргахгүй болгодог ийм л бодлогууд өнөөдөр Монголын ХАА-д хамгийн их лай ланчинг авчирч байгаа. Улс төрийн шийдвэр нь илүү гардаг. Бодит одоо энэ бизнесийнхээ шийдвэрүүд дээрээ бодлогоо одоо авч явах зайлиггүй шаардлагууд байгаа.

Тэгээд улаан буудай дээр одоо бас тодорхой хэмжээнд цавуулаг багатай улаан буудай дээр асуудал үүсэх юм байна, худалдан авахгүй, улаан буудайн нөөц бололцоо дутах юм байна гэсэн ийм мэдээлэл байгаа. Бараг зуу гаруй мянган тонноор дутах. Энэ өөрөө тонн дээр ирсэн 180000 тонноор дутах, тэгэхдээ өгсөн тоо 2 чинь бол бас бодитой бус байна. Энэ ОХУ гэхэд энэ жил зуун гучин сая тонн улаан буудай авсан, Казахстан гэхэд гуч гаруй сая тонн улаан буудай авчихсан. Тэгээд тэр улсууд өнөөдөр 700000 төгрөгөөр улаан буудайгаа зарж байгаа. Монгол улсад энэ жил ер нь улаан буудай ямар үнээр та бүхэн маань тэр ААН-үүдээсээ авах гэж байна, өрөндөө? Тэгээд үнэ тогтоох гэж байна. Энэний ачааллыг Монголын иргэн болгон үүрдэг энэ асуудал маань эргээд энэ жил давтагдах уу? Энэ асуулт байна.

Дээрээс нь энэ өнөөдөр хамгийн их санаа зовж байгаа тэр дизель түлшний асуудал ер нь ЗГ-ын гишүүний хувьд та нэг мэдээлэл авсан уу? Хэзээ энэ хэвийн болох юм бэ? Дээрээс нь энэ мал эмнэлгийнхнээс нэг асуулт асууж байна. Энэ арьс товруутах болон одоо зарим нэг өвчнөөс малыг заазалсан түүний үнэ

яаж тогтох вэ? 23 онд бас хэдэн төгрөг суулгасан юм байна.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд Болорчулуун сайд ургацын баланс, тарианы будааны цавуулаг, хүнсний хэрэгцээг хангаж чадах эсэх.

**Х.Болорчулуун:** Ганибал гишүүний асуултад хариулъя. ХАА-н салбар хамгийн их хөнгөлөлт авдаг. Тэгсэн мөртөө бүх бүтээгдэхүүн нь үнэтэй байна гэж байна. Ялангуяа гурилын үнийг хэлж байна. Өнгөрсөн жил бол улаан буудай үнэ 650-660 мянгаар авч байсан, энэ жил бол 900-аас сая төгрөгөөр улаан буудай авч байгаа. Улаан буудайн үнэ өссөнтэй холбогдуулан гурилын үнэ өссөн. Гурил өдөр тутмын хэрэгцээ болохоор зайлиггүй бас нэг тодорхой хувьд өсөхөд хүмүүсийн амь амьжиргаа дээр бол эмзэг тусдаг бусад барааг бодвол. Гэхдээ өөрөө сая хэллээ. ОХУ-аас 700 мянган төгрөг орж ирэхээр байна гэж. Яг тооцоогоор сая нэг зууаар орж ирэхээр байгаа гааль, НӨАТ-гаа нийлээд. Хэрэв гааль, НӨАТ-ыг нь хөнгөлвөл арай багасна. ОХУ ч гэсэн улаан буудай болон одоо гурилын үнэ манайхаас одоо үнэтэй биш байна. Яг дэлхийн зах дэлхийд одоо үнэтэй гурил будаа идэж байгаа гэвэл энэ бас өрөөсгөл болох байх гээд хэлье.

Хоёрдугаарт, ОХУ зуун тавин сая тонн улаан буудайг энэ жил авсан байна. Түүхэндээ сүүлийн 30, 40 жил аваагүй улаан буудай авсан гэж хэлж байна. Манайхаас улаан буудай аваач гэсэн саналыг тавьж байна. Бид бол манай ХХААХУ-н яамны бодлого бол тариалалтынхаа улаан буудайг бор шар гэхгүй одоо гурилын үйлдвэрүүд голохгүй шилэхгүй авсны дараа одоо дутагдах шинж гарвал улаан буудай оруулах асуудал тодорхой хэмжээгээр оруулах асуудал хавраас ярихаас биш тэрнээс наана улаан буудай оруулахгүй гэсэн ийм бодлого чиглэлтэй байгаа. Урьд өмнө нь бол бас 200 гаруй мянган тонн улаан буудайг 1 жилд оруулж ирж

тариаланчдадаа бас хүндрэл учруулсан гэдгийг хэлье.

Тэгэхээр бол ямар ч байсан хавар хүртэл бол гаднаас улаан буудай оруулахгүй. Манай улс бол энэ жил 400 шахам мянган тонн улаан буудай хүлээж одоо хурааж авлаа. Үүнээс бол 300-гаад мянган тонн гурил үйлдвэрлэхэд хэрэглэх 280-300 мянган тонн. Тэгэхээр бол улаан буудай үндсэндээ одоо хангагдахаар байгаа гэдгийг хэлье. Орос, Монголын ЗГ-ын хурал дээр тэр шатахууны асуудал ярьсан уу гэж асуулаа. Бидний яг хуралдааны үеэр эндээс Уул уурхайн сайд Ганбаатар сайд яг шатахууны асуудлыг тавьсан, ингээд шатахуун одоо ховордож эхэлж байна. Ингээд өнгөрсөн сард бол энэ шатахууны нийлүүлэлт ОХУ-аас яг одоо бас багаслаа, тодорхой хэмжээгээр. Тийм учраас цаашид шатахууныг нэмэгдүүлэх талаар бас асуудлыг хэлж өгөөч гээд энийг ЗГ-ын хуралдаанд ярьсан. Нэмэгдүүлье гэж одоо хэлж амласан гэдгийг бас хэлье. Түлш шатахууны хувьд бол. Өөр чинь юм асуугаагүй байхаа, баярлалаа.

**Г.Занданшатар:** Тэр мал эмнэлэг, мал эмнэлэг.

**Х.Болорчулуун:** Мал эмнэлэг, тэр товруутах өвчний талаар хариулъя.

**Г.Занданшатар:** 82. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Дамдинжавын Батчулуун.

**Д.Батчулуун:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Үрхийн арьс товруутах өвчин 2021 онд Монгол Улсад анх удаа оношлогдсон. Тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс илэрхий шинж тэмдэгтэй үхрийг устгасан байгаа. Нийтдээ ил шинжэ тэмдэгтэй үхэр устгасан, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн ажлын зардал 3.4 тэрбум төгрөгийг 2023 оны Мал эмнэлгийн ерөнхий газрын төсөвт бол тусгагдсан явж байна. Он гараад оны 23 оны нэгдүгээр улиралд багтаан одоо хохирлыг



бүрэн барагдуулахаар бид нар ажлаа зохион байгуулаад явж байна. Үнэлгээ Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр тухайн орон нутгийн үнэлгээний 90 хувь бол хувиар бол тооцож хохирлыг бол барагдуулдаг байгаа. Баярлалаа. Хүрнэ, манай дээр ирсэн орон нутгаас ирсэн тооцоо дээр бол 3.4 тэрбум гэсэн.

**Г.Занданшатар:** Одоо Салдангийн Одонтуяа гишүүн асууна.

**С.Одонтуяа:** Тэгэхээр сая ҮСХ-ны мэдээллүүд гарсан. Би бас энэ дээр тулгуурлаж хэд хэдэн дүгнэлтийг хийе. Энэ хэрэглээний одоо өрхийн хэрэглээ 20 хувь буурахад 467000 иргэн нэмж ядууралд өртөнө гэсэн ийм тооцоо байгаа. Тэгэхээр бид нар чинь бол ер нь айлуудын өрхийн хэрэглээ бол их буурчихсан. Тэгэхээр одоо бараг 3 хүний биш 2 хүн тутмын нэг нь ядуу болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр бид нарт бол энэ ерөөсөө хөрш орны туршилага байна шүү дээ яаж ядуурлаас гарсан юм бэ гэхээр ерөөсөө л энэ жижиг үйлдвэрлэгчдийг л нэмсэн. Энэ жижиг үйлдвэрлэгчдийг нэмэхэд манайд юу, би бол маш олон л хүмүүстэй уулзахад юу гол нь хэлдэг вэ гэхээр нэгдүгээрт яамны хүнд суртлыг халах хэрэгтэй. Хоёрт хөнгөлөлттэй зээл байхад бид нар бүх юмыг өөрсдөө хийчихнэ л гэдэг.

Тэгэхээр энэ хүнд суртлыг бууруулах дээр та одоо шинэ сайд байна, онцгой анхаарч ажиллаач гэж би бүр хүсмээр байна. Яагаад гэхээр энэ сая бизнесийн орчны үнэлгээ гээд дэлхийн үнэлгээ гарахад 160 орноос Монгол Улс маш олон үзүүлэлтээр 143, 150, 152 дээр л тууж яваа байхгүй юу. Тэгэхээр чинь яаж хүмүүс бизнес хийх вэ дээ. Бизнес хийх бол үнэхээр бүр хүнийг одоо махыг нь идсэн л ажил болчихоод байгаа юм. Тэгэхээр та бол бас Улсын Их Хуралд сууж байсан хүний хувьд, өөрөө бизнес эрхэлж байсан хүний хувьд энэ хүнд суртлыг халах дээр нэг дорвитой том ажил хийгээд өгөөч. Ялангуяа хөдөө орон нутгийнхан яадаг вэ гэхээр яам гэдэг

газар очихоор жижүүр угтдаг. Хэнтэй уулзах юм бэ? Тэр хүнтэй уулзъя гэхээр цаг авсан юм уу, аваагүй байхгүй хуралтай гээд. Тэгэхээр энэ хөдөө орон нутгаас ирж байгаа хүмүүсийг яам нэг одоо иргэдэд үйлчлэх төв гэж гаргаад тэндээ хүн ороод ядаж л нэг өргөдлөө суугаад биччихдэг, нэг мөнгөө төлөөд нэг халуун цай аваад уучихдаг юм иргэдэд үйлчлэх төв бол байх ёстой.

Бид нар одоо энэ яам гэхээрээ л нэг тийм цоожтой хаалга гэдэг хандлагаа өөрчлөх ёстой. Сая тэр Итэвоны осол бол ерөөсөө цагдаагийнхны тэр харилцаа хандлагаас л маш том аваар осол гарлаа шүү дээ, юм дутаагүй. Тийм учраас та энэ дээр 1 онцгой анхаараад өгөөч. Би бас энэ чиглэлээр танайд одоо очиж бас уулзаж, хамаагүй бид нар бас гишүүдийн хувьд дэмжиж туслаад ярилцаад, энийг бол энэ хөдөө орон нутгаас ирсэн иргэдэд ингэж үйлчлэх ёстой.

Дээрээс нь тэр одоо бид нар энэ валют олох арга дээрээ л нэлээд сайн дорвитой арга хэмжээ авахгүй бол өнөөдөр Монгол Улс валютын хомсдолд орж байна. Би бас өчигдөр тэр дулааны аргаар боловсруулагдаж байгаа мах гараад эхэллээ гээд би бас сонсоод баярлаж л байна. Үнэхээр бас валют нь орж ирэх юм байна, тэгээд л мал бас гараад эхэллээ бас болж л байна, ингээд малчид маань мөнгөтэй л болж байвал одоохондоо бол болж байна шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлээр бол таныг яах вэ бас шинэ ажлаа авангуутаа дэмжээд ажиллаад байгааг бол би бол бас дэмжиж байна. Би саяхан явж байгаа тэр ХХААЯ-ны нэг инкубатор төв гэдгийг орж үзлээ. Тэр мөөгний болон бялаг, энэ бусад хүнсний зүйлүүдийг нутагшуулах, кластерыг нь дэмжээд нэг ийм байр гаргаад ажиллаж байна. Одоо энэ чиглэлээр ингээд жижиг юунуудаа дэмжээд, дэмжээд одоо явмаар байна. Мөөгний кластерынхан бол маш их ажиллаж байна л даа. Тэгэхдээ бид нарт бол бас дэмжлэг хэрэгтэй л гэж байна.

Яагаад гэхээр гаднаас их хэмжээний валют орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд байгаа юм.

Нэг юм асууя. Бид нар чинь Улсын Их Хурлаар гурилын үнэ, ургамлын тос гээд ингээд урамшууллууд өгсөн. Энэ дээр ер нь үр дүн гарсан уу? Иргэдийн одоо хэлж байгаа гомдлоор бол энэ талаар ерөөсөө энэ үнэ чинь буурсангүй шүү дээ гэсэн ийм зүйл ярьж байгаа. Тэгэхээр энэ жсдү-гийн хөнгөлөлттэй зээлийн асуудал бол ерөөсөө л гол асуудал, ерөөсөө л жсдү эрхлэгчдийн гол асуудал. Үгүй ээ, тэр Хөгжлийн банкны нэг компани зуун тэрбумыг өгөөд алдчихсан байна шүү дээ. Үгүй ээ, тэрний оронд 10, 10 саяын тоног төхөөрөмж гэхэд л хэдэн хүнд энэ 10000 хүнд өгөх ийм боломж байсан л байгаа байхгүй юу. Одоо энэ хүмүүс чинь жижиг, жижиг тоног төхөөрөмж хэрэгтэй. Ерөөсөө Хятад чинь ингэж л ядуурлаас гарсан байдаг шүү дээ. Нэг нь нэг одоо үр тариагаа бутлах, нэг нь юмаа боож савлах, хатаах гээд. Тэгэхээр энэ олон хүнд хүртээлтэй болох энэ чиглэлээр дарга, сайд маш сайн ажиллах хэрэгтэй байна. Бид нар ядуурлаас гарна гэдгээ нэг гаднаас л юм гуйхыг л ойлгоод байгаа юм. Ядуурлаас гарна гэдэг чинь бүх хүнээ ямар ч байсан нэг өрхийн үйлдвэрлэл эрхлүүлээд, өрхийн амьжиргаагаа өөрсдөө одоо залгуулдаг хэмжээнд бол бас очих ёстой юм.

Тэгэхээр одоо нэг л их том, том юм л бид нар яриад байдаг юм. Гэтэл яг боломж нь өрхийн үйлдвэрлэгчид өөрт нь байгаа. Өрхийн үйлдвэрлэгчид жоохон зээлийг нь өгчихмөөр байна, өрхийн үйлдвэрлэгчид нэг туслан зөвлөх үйлчилгээг нь үзүүлчихэд Монгол Улс өөрөө дороо босоод ирнэ. Монгол хүмүүс бол үнэхээр нэг юмыг нэг, нэг юм санаа авчихвал дор нь дуурайгаад л хийчихдэг шүү дээ сэргэлэн. Тэгэхээр энэ чиглэлээр нь л одоо яам ажилламаар байна. Тэгээд энэ хүнд суртлыг буулгах тал дээр одоо танд бол бид нар том үүрэг даалгавар өгье.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

**Х.Болорчулуун:** Одонтуяа гишүүн бас өрхийн хэрэглээ 20 хувиар одоо буураад л энэ талаас явагдахад л хэдэн мянган хүнээр одоо ядуурал нэмэгдэнэ гэж бас хэлж байна. Үнэхээр үнэн. Үнэхээр манай ХХААХҮЯ салбарын хувьд бол ДНБ-ний 25-28 хувийг одоо үйлдвэрлэдэг мөртөө нийт одоо Монгол Улсын ажиллах боловсон хүчний тавь гаруй хувийг хангадаг юм байна. Тэгэхээр бол татвар төлөхөөсөө илүү бас ажлын байрыг ихээр болгодог нийгмийн ийм хариуцлагатай ийм талбар л юм л даа. Тийм учраас бол энэ хүнс ХАА-н үйлдвэрийн салбараас бол бас Монгол хүний амь амьжиргаа, ажлын байр маш их шалтгаалдаг юм гэдгийг бас хэлье. Ер нь өөрөө хэллээ сая хөнгөлөлттэй зээл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн зээлийг сайн олгох хэрэгтэй гээд. Сүүлийн 2 жил жижиг дунд үйлдвэрлэлийн зээл Улсын Их Хурал дээр хасагдсаныг та бүхэн мэдэж байгаа. Эргэн төлөлтөөрөө нэг 20-30 тэрбум төгрөгийг л одоо 25-35 тэрбум төгрөгийг эргэн төлөлтөөрөө буцааж ААН-үүдэд үйлдвэрлэгч нарт бол олгож байгаа гэдгийг бас хэлье. Тэгэхдээ олонх шалгуурт нь бол өөрчлөлт орсон. 7 хүн байдаг, тэрний 4 нь олон нийтийн байгууллагын төлөөлөл ордог. Аль болохоор шударга, ил тод байлгахыг одоо анхаарч ажиллаж байгаа.

Өөрөө хүнд сурталыг одоо анхаарах хэрэгтэй. Үнэхээр тийм. Яамны хүнд суртал гэдэг бол манайд их байна гэдгийг ард иргэдэд хэлдэг. Хүнд суртлыг арилгахын төлөө тушаал шийдвэр гаргаад байгаа яамны газар, хэлтсийн дарга нар аливаа хүний өргөдөл гомдлыг дарагдуулах, хугацаатай хариу өгөхгүй байх энэ тэр бол арга хэмжээ, хариуцлага тооцохоор шийдвэр гаргасан байгаа гэдгийг бас хэлье. Мөн одоо тэгээд энэ мал махны экспортод гаргахад квот өгдөг гэж бас маш хүнд сурталтай байсан. Үүнийг үхрийн

махнаас бусад бүх төрлийн махан дээр бол ямар ч квотгүй болсон гэдгийг болгосон гэдгийг бас хэлье. Үхэр таван сая гаруй байгаа. Далан сая малын одоо манайх 5.8, 5.9 сая үхэртэй л байгаа юм. Үхэр бол хамгийн цөөхөн гэж хэлье. Пүрэвдорж гишүүн өөрийнхөө асуулт асуух асуулт дээр асуучихъя. Хоёр.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Зочид, гүйцээгээд хариулъя.

**Х.Болорчулуун:** Гурил дээр урамшуулал өгсөн. Тэгээд үнэ нь өндөр байна гэж байна. Хэдийгээр Их Хурлаар 4 сард одоо тогтоол гарсан, та бүхэн мэдэж байгаа. Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах гээд. Гэхдээ тэр бол одоо инфляц ерөнхийдөө энэ гурилын үнийн зардлын өсөлт бол 50 хувьтай болчихсон байхад нэг 10 хувийн өсөлтийг л одоо хамгаалах ийм тийм тогтоол гэсэн гэж ойлгож болно. Яагаад гэвэл 15, 6 хувьтай зээл авахад тэрний 6 хувийг нь хөнгөлөөд, 10 хувийн, 10 хувийг нь хөнгөлөөд 6 хувиар олгоно гэсэн үг. Гэтэл яг өнөөдрийг хүртэл гурилын үйлдвэрүүдэд тэр хөнгөлөлттэй зээл очоогүй байгаа. Энэ бас нэг Монголбанк, Сангийн яам тэр хүнд суртлаас болж байна гэдгийг бас хэлье. Ер нь тэгээд үйлдвэрлэгч нар бол бас ингэж тэрийг олгох хүлээгээд байгаа. Олгохгүй бол дахиад бас нэг үнэ нэмэгдэх бас нэг болно гэж бас нэг хэлээд байгаа гэдгийг бас хэлмээр байна. Ойрын хугацаанд энэ асуудал шийдэгдэнэ. Энийг бол шахаж ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Ер нь жижиг, дунд үйлдвэрлэл дэмжих хэрэгтэй, тоног техник, тоног төхөөрөмжийг бол одоо бид нар гаалийн татвараас чөлөөлдөг байгаа жил болгон жижиг, дунд үйлдвэрлэлийн. Гэхдээ сүүлийн 10 жилд нэг их наяд гарны жижиг дунд үйлдвэрийн зээл олгосон байна, бага хүүтэй зээл. Тэгсэн мөртөө одоо дорвитой, бас жижиг дунд үйлдвэрлэл манай улсад хөгжсөөгүйг

мэднэ. Ер нь зах зээлийн нөхцөлд бол хүн юм хийж үйлдвэрлэж чадна, болно. Хамгийн гол нь борлуулалтыг бид нар хамгаалах, дэмжсэн бодлого бол дутагдсан юм байна лээ. Бид нар хийж чаддаг зүйлээ гаднын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн Монгол Улсад орж ирэхээс хамгаалахгүйгээр тавхан хувийн гаалийн татвартай байна гэдэг ямар ч үйлдвэрлэл явах, хөгжих боломжгүй. Ялангуяа үйлдвэрлэгч энэ 2 хөршийн дунд байгаа манай хувьд бол үнэхээр боломжгүй юм. Тийм учраас ер нь энэ намрын чуулганаар ЗГ-аар дамжуулаад Улсын Их Хурал хийж чадаж байгаа, хийж чадах зүйлийнхээ импортын гаалийн татварыг үйлдвэрийнхээ өсөлттэй уялдуулаад 2-3 жилдээ, бас жилийн хугацаанд бас үе шаттайгаар нэмэгдүүлэхээр хуулийн төсөл оруулж ирж байгаа шүү.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал Учралын урилгаар Ерөнхий боловсролын Орчлон сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Сайн суралцаж, сайн хүмүүс болцгоогоорой гэж. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөрөө тогтоно гэж байгаа юм. Үгүй ээ, Валдимир Ильич Ленин хэлээгүй Ганибал гишүүнээ. Владимир Ильич Ленин чинь сур, сур бас дахин сур гэж хэлсэн юм. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах цаг өөрөө тогтоно гэж жанжин Сүхбаатар хэлсэн юм. Ингээд одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр энэ асуудал маш одоо цаг үеийн чухал асуудал орж ирж байна. Тэгээд энэ танилцуулгыг бүгдийг нь одоо уншиж танилцлаа. Тэгээд бас тодорхой хэдэн одоо асуудал асуулт байна. Манай одоо Монгол Улсын хэмжээнд өнгөрсөн зун

бас төвийн бүс, зүүн талдаа бол харьцангуй одоо сайн зуншлага сайн байсан. Баруун тал, баруун 5, 7, баруун 5, 7 ч гэлтгүй, одоо энэ Баянхонгор, Өвөрхангайн урд талын говьд, говийн сумд энэ тэр гээд ингээд зуншлага, намаржаа их тааруу болчихлоо. Тэгэхээр энд юу хэлж байна гэхээр эндээс тэр холоос хүмүүс бол бүгдээрээ нүүгээд явах, ийм отор хийгээд явах боломж байхгүй. Тэгэхээр энэ одоо зуншлага гайгүй аймгууд руугаа ингээд отор нүүдэл хийж байгаа. Тэгээд ингээд отор нүүдэл хийгээд ирэхээр ер нь бол Монгол Улсын хэмжээнд түрүүн хэллээ шүү дээ. Хонин толгойд шилжүүлснээр 120 гаруй сая толгой малтай болчихсон. Хуучны одоо манай одоо эрдэмтдийн судалгаагаар бол Монголд бол нэг, далан сая толгой хонин толгойд шилжүүлсэн мал байх л бэлчээр байгаа гээд. Тэр цагаас хойш бол зуншлага ч муудсан, цөлжилт ч их болсон.

Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээр хаана хаанаа эрсдэл авчирдаг. Оторлож байгаа хүмүүс ирээд ч тэр, нөгөө сууж байгаа хүмүүстэй цуг идээд ингээд 2-уулаа эрсдэлд ордог. Тэгэхээр энэ отрын асуудал дээр ЗГ дээр ер нь шийдсэн ярьсан, онцгой байдлынхантай, аймаг орон нутгийнхантай ярьж шийдвэр гаргасан ийм асуудал байгаа юу гэсэн ийм одоо асуудлыг асуулт асууя.

Энэ юун дээр мал дээр болохоор ингээд борлуулалтыг нь ингээд харахаар энэ жил бол хорин сая толгой мал эргэлтэд оруулна гээд. Монголчууд бүгдээрээ одоо махны үйлдвэр, энэ хүнсний үйлдвэртэйгээ иргэд бүгдээрээ хэрэглээд, хэрэглээд нэг 15 сая толгой мал хэрэглэнэ. Үлдсэн мал бол иүүд илүүднэ. Энэ малыг одоо малын махыг хааш нь явуулах ийм бодлого байна вэ? Гадагшаа гарч байгаа махны экспорт чинь хангалттай биш, бага байгаа. Тэгэхээр энэ одоо малчдын зүгээс ярьж байгаа зүйл байгаа шүү дээ. Мах малаа борлуулаад махаа борлуулаад ерөөсөө орлого олж чадахаа больсон. Нэг мөнгөн

дүн нь 5, 6 мянга энэ тэр гээд одоо дүн байгаад байгаа боловч бөөний үнэ. Тэр чинь эргээд тэрийг борлуулсан мөнгөөр одоо бараа бүтээгдэхүүн, хүнс худалдаж авахаар нэг дахин бага юм орж ирээд байна. Тэгэхээр энэ махны үнэ борлуулалт тал дээр одоо ямар арга хэмжээ авч байна вэ?

Аубакир гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг Их Хурал дээр бүр арга ядаад байгуулагдсан. Одоо ажлаа бас маш шуурхай ингээд хийж байгаа. Маш олон элчин сайдууд, яамнууд, харьяа байгууллага, махны үйлдвэрүүд гээд ингээд төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа юм. Гадныхны хэлж байгаа нэг л юм байгаа шүү дээ. Танай дотроос чинь маш их хүнд суртал байна. Нэгдсэн зохион байгуулалт нэг шугамаар, нэг цонхоор явдаг ийм зохион байгуулалт алга. Нэг байгууллага нь нэг юм ярьдаг, нөгөө байгууллага нь өөр юм ярьдаг гээд ингээд асуудал ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас энэ ХААЯ-ныхан маш энэ ажлын хэсэгтэй бусад одоо хувийн хэвшлийнхэнтэй маш их нягт хамтарч ажиллах ийм одоо шаардлагатай байгаа юм.

Энэ нөөцийн махан дээр одоо энэ бодлогыг нь ХААЯ авч явах уу, энэ нийслэл нь авч явах юм уу? Энийг нэг хариулаад өгөөч. Энэ дээр шинэчилсэн ямар нэгэн бодлогын өөрчлөлт бол байгаа юу?

Нөгөө л зуншлага намаржаа муудаад ирэхээр одоо бас л нөгөө өвсний хадлан хадах гэдэг асуудал бол бүр хүнд болсон. Энэ жил өвсний үнэ одоо одоо намар халуун намраар Улаанбаатар хотын орчимд гэхэд л 10000 гараад явчихсан. Ногоон тэжээлийн үнэ гэхэд л 12000 гараад явчихсан. Өвөлжилт хүндрэх газар хүндэрвэл энэ өвс тэжээлийн үнэ ингээд маш өндөр болох нь. Бид нар нөгөө өнгөрсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор энэ эрэлтэд суурилсан нийлүүлэлтийн бодлого гэдэг юмыг ер нь



гаргая гээд ярьсан. Одоо болтол таг, энийг анхаараач. Тэгэхгүй бол ноднин жил ногоон тэжээл өвсөн дээр маш илүү үйлдвэрлэл хийчихсэн, сайхан өвөл болчихсон. Энэ жил дутуу тарьсан чинь үнэ нь өсөөд явчихсан. Ийм баймааргүй байна гэдгийг бас хэлье.

Мал эмнэлэг дээр маш их учир байна. Энэ малын гоц халдварт өвчин гээд л. Гарсан өвчнийг тэгж эдгээлээ, тэглээ гээд л олон тэрбум төгрөг зарцуулснаа л яриад байх юм, Уг нь бол урьдчилан сэргийлж хамгаалах ёстой юм байгаа биз дээ? Тэгээд нэг гавьяа байгуулчихсан юм шиг ингээд Фэйсбүүк одоо бусад юм хумаар ингээд л тийм юм тэнд гарлаа гээд сурталчлаад байна. ААН-үүд маш их одоо ярьж байна шүү дээ. Ядаж энийгээ больчихож болдоггүй юм уу? Дотооддоо бүтэн нэгдмэл улс байна, энэ талын мэдээллээ жоохон нууцлаад тэр албан юман дээрээ л хэрэглэж болдоггүй юм уу. Бид нарыг мах гээд ингээд явахаар танайх өвчинтэй худлаа гэвэл одоо баталгаа нь энэ байна гээд ингээд өөдөөс гараад байгаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах уу? Хаянгаагийн Болорчулуун. ХХААХҮ сайд.

**Х.Болорчулуун:** Тэр отрын тал, Туваан гишүүний асуултад хариулъя. Отор нүүдлийн талаар асууж байна. Үнэхээр манай улсын хувьд бол одоо цаг агаарын байдал энэ дэлхийн дулаарал бол манай улсад маш их хүчтэй нөлөөлж байна. Зундаа одоо их гандаж байна, ялангуяа баруун болон баруун урд нутаг нутагт 6, 7 аймаг бол нэлээн гангийн байдалтай гэдгийг түрүүнд би хэлсэн. Түүнээс гадна одоо өөрийн чинь саяын хэлдгээр үнэхээр малын тоо толгой өссөн. Төлтэйгөө нийлээд энэ зун гэхэд ерэн сая мал хүрлээ шүү дээ энэ чинь тэгэхээр бас туурайн зуд болох нэг үндэслэл болчхож байна. Тэгээд отор нүүдлийг бол одоо гантай аймгуудаас аймаг дундын отрын бүс, 8 бүс байдаг. Энд бол одоо дотор нүүдэл хийх

хуваарийг гаргаж хүргүүлээд байгаа гэдгийг бас хэлье.

Малчид махны үнэ хямдраад борлуулахад орлого олохгүй болж байна гэж үнэхээр үнэн. Мал, махны үнэ бол урьд өмнө байгаагүй маш хямдарлаа. Бас энэ бол энэ зуны хувьд манай экспорт тасалдсантай бас холбоотой гэж би бас үзэх байна. Бид нар нэг гэнэт нэг улс төрийн шийдвэрээр ч юм уу, сошиалд хөтлөгдөөд ч юм уу, шийдвэр гаргаж бол болдоггүйг энэ Эмээлтийн махыг урагшаа гаргаж байсан явдлыг хаасан байдал бол харуулж байгаа юм. Эргээд энэ намар 6, хавар хаасан. Намар ингэж гаргахад Хятадын тал бол урьд өмнө нь бэлдсэн мах авахгүй, зөвхөн 5 сараас хойших шинэ мах авна гэсэн асуудлыг тавьсан. Харин одоо хэдхэн хоногийн өмнөөс одоо арваад чингэлэг мах урагшаа гарч эхлээд байгааг хэлье. Мөн Казахстан улсад адууны мах бас нэлээн гарч байна. Мөн Арабын нэгдсэн эмират улсад мянган тонн махны гэрээ нэг ААН хийгээд байна. Зөвхөн 2 хөршөөр хязгаарлагдахгүй энэ арабын орнууд Казакстан, Узбекстан энэ тэр бол манай махыг авах их сонирхолтой байгаа гэдэг юм. Тэгэхдээ бол одоо аль ч бас эрүүл малын мах гэдгийг бол хэлж байна. Яг үнэндээ бид нар бол өнөөдрийг хүртэл малаа эрүүлжүүлэх тал дээр бол бас алдаа гаргасныг бол хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Ялангуяа улс орнууд мал, мах, махаа гаргах, экспортод гаргахдаа эрүүл бүсүүдийг гаргадаг, байгуулдаг нутгийнхаа хэсэг хэсэгт. Манайх бол тэрийг байгуулаагүй, нутаг даяараа Монгол Улсынхаа хэмжээнд эрүүл болно гэсэн байдлаар хандаж, тэр нь бол аль ч улс оронд тийм боломж байдаггүй юм байна лээ. Ингээд мал, мах өнөөдрийг хүртэл бас эрүүлжиж чадахгүйгээс болж бас хорио цээрт ороод байсан гэдгийг бас хэлье. Энэ чиглэлээр бол эрүүл бүс байгуулж, махаа олон улсын жишигийн дагуу экспортод гаргах чиглэлээр одоо ХХААХҮ яам ажиллаж байгаа. 3 баруун, зүүн, хойд 3 хэсэгт



эрүүл бүс байгуулахаар одоо ЗГ-ын тогтоол гарч байгаа гэдгийг бас хэлье.

Нөөцийн махан дээр бол би бас тантай яг санал нэг байна. Яг үнэндээ ХХААХҮ яам үйлдвэрлэлийн яам. Яг нөөцийн махыг бол тэр нийслэл хот нь бол өөрсдөө бол иргэдээ махтай байлгах, тэр махны хомсдлоос сэргийлэх үүднээс нийслэл нь өөрөө бэлдэж байх шаардлагатай юм. Тэр мөнгө төгрөгийг нь ч гэсэн тэр нийслэл нь өгч байх ёстой гэсэн асуудлыг бол ЗГ-т Ерөнхий сайдад бас тавиад байгаа. Энэ жилийн хувьд бол тэгээд ер нь нөөцийн махан дээр түрүүнд зуун гучин тэрбум төлөвлөсөн боловч 50 хувийг нь ч одоо ААН-үүд ашиглаагүй шүү дээ. Учир нь бол өнгөрсөн жилийн нөөцийн махан дээр бол ААН-үүд нэлээн алдагдалд орсон, хаширсан. Тэгээд нөөцийн махны бэлтгэл бол иймэрхүү хагас дутуу байгаа гэдгийг хэлье. Ер нь цаашидаа бол энийг нийслэл өөрөө бэлдэх нь зүйтэй гэдгийг ерөөсөө хэлье. Мал эмнэлгийн гоц халдварт өвчин юу гэлээ мал эмнэлэг хариул даа.

**Г.Занданшатар:** 82 Батчулуун дарга хариулъя.

**Д.Батчулуун:** Туваан гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хавар 4 сарын 1-ний байдлаар шүлхий өвчний асуудал бас нэн хүнд байсан. 20 аймгийн 200 орчим суманд бүртгэлтэй байсан, бүртгэгдсэн байсан. Өнгөрсөн хугацаанд шүлхий хүчинтэй тэмцэх богино хугацааны тактик, дунд хугацааны стратегийг 2027 он хүртэл хэрэгжүүлж гэсэн ийм байдлаар боловсруулаад ажиллаж байна. Мөн бог малын мялзан өвчинтэй тэмцэх, сэргийлэх тактикийг бол шинэчлэн баталсан. Эдгээр стратеги тактикийн хүрээнд өнөөдрийн байдлаар Монгол Улсад шүлхий өвчний одоо хорио цээртэй, аймаг, сум, баг, хот айл байхгүй байгаа. Цаашидаа энэ эрүүл мал, эрүүл гэдэг гэдгийг баталгаажуулах, тайван байдлыг хангах талаар бол Мал эмнэлгийн ерөнхий газар

бас тодорхой хэмжээний арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Отор нүүдэл хийж байгаа мал мах бэлтгэж байгаа энэ аймаг, сумдад бол Мал эмнэлгийн ерөнхий газраас мөн одоо шат шатны мал эмнэлгийн байгууллагаас эрсдэл байхгүй, эрсдэл багатай энэ бүс нутгаас бэлтгэх энэ чиглэлийг бол бид нар зөвлөмж болгон хүргүүлсэн ажиллаж байна. Нөгөө талдаа бол ДМАЭМБ-ын гишүүн орны хувьд бол тухайн одоо гоц халдварт өвчин гарсан тохиолдолд зохих байгууллагууд нь мэдэгдээд явж байдаг. Энэ мэдэгдэх хугацаа маань тодорхой хугацааны дараа мал эмнэлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлээд, хорио цээр татан буугдсаны дараа энэ мэдээллээ бас цуцалдаг байгаа. Өнөөдрийн байдлаар ДМАЭМБ-ын веб сайт дээр мэдээлэл дээр Монголд бол шүлхий өвчний тохиолдол огт бүртгэгдээгүй байна. Бог малын мялзан өвчний хувьд бол өнөөдөр Архангай, Булган, Дундговь аймгийн зарим сумд дээр бол хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна. Тухай бүрд нь бид Мал эмнэлгийн ерөнхий газар, шат шатны байгууллагаас мал эмнэлгийн байгууллагуудаас арга хэмжээ аваад хэрэгжүүлээд явж байна.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би та нарт статистик харуулна. Малын тоо 2016 онд 75 сая тоо толгой барьсан, тэр үед 2016 онд 80000 тонн мах экспортолж байсан байна. Гэтэл өнөөдөр 2022 онд малын тоо 91 сая толгой болсон. Гэтэл өнөөдрийн байдлаар 3000 тонн мах экспортолж байна. Энэ юунаас болж байгаа юм гэхээр хүнд суртлаас болж байгаа. Тийм учраас Их Хурал дээр ажлын хэсэг гараад Аубакир гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарч байгаа. Хэд хэдэн яамдын сайдтай уулзаж юу ЭСЯ-дын одоо тэргүүнүүдтэй уулзаж байх шиг байна лээ, ажил хийж байгаа нь зөв. Тэгэхдээ өчигдөр над дээр ирээд танай

махны холбоо чинь одоо бид нарын энэ ажил дээр ер нь дэмжиж ажиллаж байгаа юм уу гэж асууж байна лээ. Тэгэхээр нь би хэлсэн юм. Манай ямар байр суурьтай байгаа вэ гэхээр манай махны холбооны гишүүн компаниуд МАН далд ороосой л гэж бодож байгаа л гэж хэлсэн.

Өөрөөр хэлбэл тэдний бизнесийг 80000 тонн байлгаж байгаад өнөөдөр 3000 тонн болтол багасгана гэдэг бол энэ бол авлига, хүнд суртал, хээл хахуулийн энэ одоо бүх зүйл энэ одоо салбар дээр байна гэсэн үг. Квот гэдэг юмыг байна шүү дээ 2009 онд энэ хуульд орсноос хойш огт хэн ч хэрэглэдэггүй байж байгаад 2018 онд улайдаггүй Улаан сайд гарч ирээд хэрэглэсэн. Тэгээд энгийг нь сая Болорчулуун сайд тэр богын махнуудыг нь гаргаад ингэсэн байна лээ. Одоо үхэр үлдчихсэн байгаа. Адуу, үхэр үлдчихсэн байгаа. Тэгээд үхэр дээр чинь ямар авлига явж байна вэ гэхээр нэг килограмм тутамд 750 төгрөгийн авлига л яваад байна шүү дээ тэрэн дотор чинь. Өөрөөр хэлбэл квот авсан компани дээр нөгөө квотгүй компани махаа гаргахдаа нэг үхэр дээр энэ малчны хотны хотоос гарч байгаа нэг үхэр дээр 120000 төгрөгийн авлигал яваад байна шүү дээ. Тэр авлигалын мөнгө чинь малчны карманд орох ёстой байтал тэр одоо авлигалаар дамжаад тэр хүмүүс хүмүүсийн нэр дээр чинь очоод байна шүү дээ. Энийгээ боль л доо. Гурван сая толгой үхэртэй байж байхад квот тавьж болох байсан, одоо зургаан сая болчихсон байж байна шүү дээ.

Тэгээд энэ экспорт чинь одоо энэ 100000-д хүргэхийн тулд тавхан сая бог 2,5 сая яамаа, 2,5 сая хонь, дээрээс нь нэг 50000 үхэр гаргахад л 100000 тонн болох байхгүй юу даа. Тэгээд энэ экспортоо дэмжих талаар ажилла л даа. Хятад руу бүр аймаар нэг контейнер мах гаргахад 20, 25 тонн мах гаргахад тавин сая төгрөгийн авлигал өгч байна шүү дээ. Энэ квоттой чинь холбоотойгоор. Ингэхээр чинь яаж энэ малчид сайхан

амьдрах юм бэ? 2000 төгрөг гэдэг чинь тэр төлгөн дээр одоо нэг 18 килограммтай төлөг байлаа гэхэд чинь 36000 төгрөг авлигад нь яваад алга болж байна шүү дээ. Ийм юмнуудаа бүгдийг нь одоо сайжруулах тийм зайлиггүй шаардлага байна. Тэгээд сая намайг Солонгос явах хооронд амьд мал гаргаж үзэж байна лээ. Тэгээд яасан юм бэ гэсэн чинь гуравхан мянган мал гаргасан. Дарга нарын мал гаргасан тарган мал гаргасан байна лээ шүү дээ жишээ нь. Тэгээд тэр нь энэ Мэндсайхантай холбоотой юм шиг байгаа юм. Тэгээд ядарсан муусайн туранхай малчид малтай малчдын малын махыг яагаад гаргахгүй малыг гаргаад гарахгүй байгаа юм бэ.

Тэгээд өнгөрсөн энэ жилийн одоо би одоо хийх ажлуудыг чинь хэлж өгье. Энэ Монголбанкны энэ жилийн хөтөлбөр дээр хоёр зуун тэрбум төгрөгийг экспортод зориулж, махны компаниудад санхүүгийн зээл олгоно, үндэсний махны компаниуд санхүүгийн зээл олгоно гэсэн заалт орсон байгаа юм. Тэр огт хэрэгжихгүй байгаа. Тэгээд би өнгөрсөн жил тэрнийг одоо махны компаниуд авч тэр экспортыг нь дэмжих, санхүүгийн эх үүсвэрийг нь дэмжих тэр ажлыг нь хийхгүй бол энэ махны компаниуд чинь зээл байхгүй байна( банкнууд зээл гаргахгүй байна, мөнгө байхгүй байгаад байгаа. Тэр ажлыг одоо яаралтай нэгдүгээрт юу ХААЯ хийх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь нөөцийн махаа боль. Өнгөрсөн жил би зөндөө хэлсэн. Махны холбооны тэргүүний хувьд хэлж байна. Нөөцийн мах энэ жил энэ хавар гаргах хэрэггүй гээд өнгөрсөн жил хэлсэн. Энэ хавар гарсан, сүүлдээ та нар энэ нөөцийн махаа төрийн албан хаагчид шахаа биз дээ. Тэгээд энэ жил зуун гучин тэрбум төгрөг тавьчихсан. Тэгээд энэ махаа энэ мөнгөө бүгдийг нь юу руу оруул л даа ирэх жил ийм 91 сая толгой малтай болчихсон байж байхад махны үнэ буурна шүү дээ. Дөнгөж тавхан сая тонныг гаргахад л одоо энэ дөнгөж

гуравхан мянган тонн гаргачихсан явж байгаа энэ гүйцэтгэл дээр чинь энэ мах малын хүн чинь унаад, дээрээс нь махны үнэ хямдрах байхгүй юу даа. Тэгэхлээр нөөцийн ирэх жилийн нөөцийн махан дээр тавьсан тэр мөнгийг бүгдийг нь энэ жил маш яаралтай ААН-д өгөөд, ААН-ийг тэр экспортын чиглэл рүү хандуулах, тэр ажлыг нь зохион байгуулалт хийх хэрэгтэй байна. Ирэх жил нөөцийн мах хийх ямар ч шаардлага байхгүй, би дахиад хэлье.

Тэгээд дөрөвдүгээрт нь бас нэг баруун аймгаар орж ирж байгаа өвс тэжээлийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болорчулуун гишүүн, Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

**Х.Болорчулуун:** Пүрэвдорж гишүүний хэлж байгаа тэр гадагшаа гарах махан дээр хэдхэн тооны одоо компаниуд, ялангуяа Хятад руу гарах мах махан дээр одоо эрхийг нь авчхаад, тэгээд цаас зарж байсан байдал урд өмнө нь бол үнэн бий байсан. Энийг одоо таслан зогсоохын төлөө ажиллаж байна. Гэхдээ энэ Хятад, Монголын хамтарсан комиссын хуралдаанаар бол тогтохдоо бол протоколдоо бол Хятадын талаас хүмүүс ирж байж Монголын аль үйлдвэрээс мах авахыг шилж сонгоно гээд заагаад өгсөн, харамсалтай тийм юм л юм байна лээ. Тийм учраас Хятадууд тэр, тэр үйлдвэрээс авна гэдгийг заадаг. Ер нь бид нар цаашидаа бол ямар шаардлагатай мах авах вэ, тэр шаардлагынх нь дагуу одоо гарах ёстой. Хятад, Хятадын тал бол мэргэжлийн хяналт, тэр гааль бүх юм нь бол хил дээрээ л одоо тэр чанар байдлыг нь шалгахаас биш энд тийм, тийм үйлдвэрээс авна гэж заах нь бол ийм байдалд хүргэсэн ийм өрөөсгөл юм гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд энэнээс одоо зөвхөн цөөхөн хэдэн компанид одоо эрх өгөх биш, өргөн хэмжээтэй гаргахын тулд одоо бас нэг

ажлын хэсэг энэ манай Бодлого төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Ийм байдлыг бол цаашид гаргахгүйн тулд махны нэг цэгийн бодлогоор махыг гаргах, ялангуяа үнийн хувьд ч гэсэн бол бид нар өрсөлдөж, манайхан бол үнээ доогуур нь, тэгээд өөрийнхөө баялгийг бас үнэгүйдүүлдэг ийм тал бол байна. Ийм учраас махны холбоо, ХААЯ хамтарч үнийг ямааны мах, хонины мах, үхрийн мах ямар үнээр гаргах вэ энэ бодлогыг бол одоо хамтарч зөвхөн яам биш гаргаж, одоо жил жилдээ одоо ингэж тогтоох нь зүйтэй гэдгийг бас хэлмээр байна. Ялангуяа өөрөө бол махны холбооны тэргүүний хувьд бол бас энэ тал дээр бас анхаарч, хамтарч ажиллахыг бас уриалж байна.

Ер нь тэгээд экспортын талаар махны экспорт гэж олон жил ярилаа. Яг өнөөдрийг хүртэл махаа олон улсын жишигийн дагуу экспортлох арга хэмжээ бол манай улс аваагүй гэж хэлж болно. Яагаад гэвэл бүх улс орон эрүүл бүс байгуулж байж тэндээсээ экспорт мах гаргадаг юм байна. Манайх тэрийг байгуулаагүй. Эрүүл бүсийг нь одоо өмнө ирэх 7 хоногийн ЗГ-ын хуралдаанаар орно, тогтоол үндсэндээ гарна, танилцуулгыг нь бол хийчихсэн байгаа. Монгол Улсынхаа 3 газарт эрүүл бүс байгуулахаар ингэж ажиллаж байгаа. аруун тал бол баруун 3 аймаг. Аль ч улстай ярихад эрүүл мах, эрүүл мал, малын мах, аюулгүй мах мах авна л гэсэн асуудал. Тэгэхээр эрүүл бүсийг бид нар байгуулж, тэндээ бол тарилга туулга, вакцин бүх юмыг технологийн дагуу хийж байж гаднынхан эрээ цээрлэхгүй, голж илэхгүй авах ийм мах экспортод гаргах юм. Энэ тал дээр бол ажил хэрэг ирэх хавраас бол бүтээлч ажил өрнө, өрнөнө гэж хэлье.

Тэр амьд малын хувьд бол одоо яг хотынхон бол жишээ нь мах битгий амьдаар гарга л гэж ярьдаг. Малчид болгон бол амьд нь ч бай, үйлдвэрийн аргаар ч бай махаа энэ жилийн хувьд бол

гаргахыг бол хүсэмжилж байгаа. Амьд малыг бол урьд урьд нь 3 жилийн өмнө бол зөвшөөрөл гаргах зөвшөөрөл нь өгчихсөн байсан. Энд Монголын талд бол олон тэрбум төгрөгийн гуч, дөчин тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар оруулалт хийгээд шахан бордох тийм хашаа бүхий zone гаргасан, байгуулсан байгаа Дорноговь дээр. Үгүй юу Замын-Үүд дээр. Энийг бол энэ жилийн хувд бол шууд таслан зогсоох арга хэмжээ аваагүй гэдгийг бас хэлье. Нийтдээ амьд мал бол 6000 орчим хонь л гараад байгаа. Манайх чинь одоо бараг дөчин сая шахуу хоньтой шүү дээ.

Махны экспортыг гаргахад одоо компаниудад хөнгөлөлттэй зээл олгох хэрэгтэй гэж энэ би харин өөрийн чинь тэр нөөцийн махыг ингэж бэлдэх, тэр тусмаа хүнс ХААЯ энд бол оролцож оролцох нь бүр туйлын хэрэггүй гэдгийг бас одоо анхааран ажиллана. Ирэх жилээс бол манай яам бол энийгээ бэлдэхгүй. Тэр нийслэл нь бол хэд хэдэн тонн мах бэлдэхээ өөрийнхөө бас тооцоо судалгаа дээр бүх сүлжээ борлуулалт нь нийслэлийн харьяалалтай байдаг учраас нийслэлд бэлдэх хэрэгтэй. Ялангуяа зуун гучин тэрбум төгрөг төлөвлөсөн боловч одоо дөнгөж 46 тэрбумыг одоо дөрөвхөн компани аваад байна. Өнгөрсөн жилийн нөөцийн мах бэлдэнэ гэсэн компаниуд бас.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** МАА-н салбарыг үнэхээр болохгүй байна гэж хэлэхэд одоо багадаа ийм л нөхцөл байдалтай байгаа. Энэ бүтээмж гээд нэг ойлголт байдаг эдийн засагт. Энийг нь ярихад улсын дунджаас 3 дахин өндөр бүтээмжтэй салбаруудын үзүүлэлтээс бараг 10 дахин бага бүтээмжтэй. Энэний цаана чинь л нөгөө орлого гэдэг зүйл энэний цаана л яваад байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой 1 санал, 2 асуулт байгаа юм.

Эхэнд нь ер нь яг одоо бодит байдалтайгаа бид нар бас эвлэрэхээс өөр аргагүй. Ер нь Монголын махгүйгээр, Монголын сүүгүйгээр, Монголын арьс ширгүйгээр дэлхий амьдарч болдог юм байна гэдгийг бид нар үзчихлээ, харчихлаа. Стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн бол тэд нарт хэрэггүй юм байна гэдгийг бид нар харчихлаа. Харин Монголын ХАА хөгжиж дэвшихийн тулд тэр дэлхий харин бид нарт нэг хэрэгтэй юм байна. Тэр экспорт нь бид нарт хэрэгтэй юм байна гэдэгтэй одоо бид нар шууд 2 гараа өргөөд эвлэрэх л хэрэгтэй болчихож. Тэгэхийн тулд эндээс хэлэх гэж байгаа санал нь бид нар ажлыг тийм ажил хийнэ, ийм ажил хийнэ гэж олон зүйл бодож сэтгэхээсээ урдаар тэр авах гэж байгаа нөхдүүдийн стандарт шаардлага юу байдаг юм энийг бүхнийг фронтод гэдэг шиг зөвхөн тэр стандартын төлөө бүх юмыг хийвэл яадаг юм. Энэ чинь хийх ажлын зүг чиг чинь тэнд өөрөө бүгдийг заагаад өгчих юм биш үү? Тэр авахыг хүсэж байгаа бид нарын зарахыг хүсэж байгаа зах зээлд ямар шаардлага тавиад байгаа юм. Энэ тэр нь шинээр дугуй зохиох, дугуй зурах шаардлага ч алга байна шүү дээ. Тэгэхээр энэ стандарт гэдэг ажлыг энэ салбарын гол одоо жанжин шугам болговол одоо яадаг юм бэ?

Хоёрдугаарт нь нэг тодорхой асуулт нь, ер нь малчдын орлогыг та нар одоо яг яаж төсөөлж бодож байгаа юм бэ? Би сая нэг хөдөө явж байгаад мянган малтай айлд 900 богтой, 100 бодтой айлд нэг хонохдоо тэр айлтай тооцоо хийж үзсэн. Яг жилдээ танайх ямар орлого олж байна, ямар ашиг олж байна, өөрсдийнхөө хөдөлмөрийг хасвал юу гарч байна вэ? Үнэхээр харамсалтай тоо гарч байна лээ. Энэ дээр одоо хийсэн тооцоо судалгаа байна уу? 1 жилдээ нэг дөчөөд сая төгрөг, хөдөлмөр, 3 хүн жилийн турш ажиллана, тэрийгээ хасвал нэг хориод сая төгрөгийн ийм л орлогын тухай яриа гарч байна лээ. Үнэхээр харамсалтай. Би бол тэр тоонд бол



үнэхээр надад харамсалтай санагдаж байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой малчдын орлого ашигтай холбоотой, эрх баригч намын мөрийн хөтөлбөрт маш олон зүйл амласан, хөдөөгийн хөгжилтэй холбоотой. Эндээс би хоёрхон зүйл л асуучихъя. Тэр 150000 тонн мах жилдээ экспортлоно гэсэн бодлого тэр чинь одоо 20 онд амласан амлалт одоо хаана явна вэ? Энэдээ хүрч чадах уу? Ямар бодлого чиглэлтэй ажлууд хийж байна вэ? Энэ жил 3000 тонныг л гаргаж байгаа. 23 он чинь боллоо, 24 онд чинь боллоо. Энэ тоо тоон дээр нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь дахиад малчдын орлоготой холбоотой зүйл дээр арьс шир арван сая арьс шир боловсруулах гэдэг тэр зорилго, зорилт одоо хаана явна вэ? Хэдэн хувьтай явна вэ? 24 онд энэ 10 сая арьс шир боловсруулах уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Гуравдугаарт нь энэ хүнсний салбарын бас нэг хяналт гэдэг зүйлтэй холбоотой баталгаажилт гэдэг зүйлтэй холбоотой, тэр стандарттай ч холбоотой. Яг одоо үнэндээ сүүлийн үед яригдаж байгаа зүйл мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаад гээд. Манайх чинь уг нь бол төрийн хяналт шалгалт, дарамт биш байх нь зүйтэй. Тэгэхдээ би бас яг хүнсний үйлдвэрлэлтэй хамаарал бүхий хүн. Нөгөө талаасаа миний одоо төлөөлж байгаа нам өөрөө жижиг төрийг сурталчилдаг, төрийн хяналт шалгалтыг зөв зүйтэй, зохистой түвшинд бага түвшинд байлгахыг эрмэлздэг. Гэхдээ нөгөө талаасаа одоо хүний амаар дамжиж болдог хоол хүнс гэдэг зүйл одоо энэ нэг мэргэжлийн хяналтын тогтолцоо ярьж байгаа зүйлээр, ер нь тэр хяналт цаашидаа яаж явах юм, яаж зохистой явах юм бэ? Яаманд очих юм шиг, бүр татан буулгаж байгаа юм шиг. Төрийн дотоод хяналт гэж юм байх юм шиг. Энэ дээр яг ямар төсөөлөлтэй байгаа юм бэ?

Энэ чинь өөрөө хүнд суртлын биш, хяналт шалгалт гэдэг зүйл чинь зохистой түвшинд байх ёстой л зүйл. Би бас яг энэ салбарт ажиллаж байсан хүний хувьд бас тийм л бодолтой. Тэрнээс бүх юмыг чөлөөтэй, бүх юмыг одоо хяналт шалгалтгүй дураараа гэдэг зүйл, тэр тусмаа хүнс дээр бол байх бас тийм одоо ёс зүй бас байж болохгүй. Ёс зүйн түвшиний ч юм биш. Тэгэхээр эдгээрт нэг хариулт өгөөч. Эхнийх нь тэр нэг санал хэлсэн. Хоёрдугаарт нь малчны орлоготой холбоотой тэр арьс шир болоод 150000 тонн махны тухай. Гуравдугаарт нь энэ хүнсний хяналтын тухай, энэ чинь зөвхөн Монгол хүнийхээс гадна тэр экспортлож авах гэж байгаа орон чинь стандарт хангуулахын тулд олон л зүйл шаардах байх. Тэгэхээр наад тогтолцоо чинь яг хаанаа явах ёстой болж байгаа билээ гэдэг дээр.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

**Х.Болорчулуун:** Мах экспортлох гэж одоо бид нар мянган удаа ярьсан, үе үеийн яамны удирдлага ЗГ ярьдгийг мэдэж байгаа байх. Яг өнөөдрийг хүртэл яг үнэнээ хэлэхэд бол олон улсын жишигийн дагуу махаа экспортлох ажлыг манайхан хийгээгүй ирсэн. Энэ юу гэвэл би түүрүүнд хэлсэн бүх улс орон эрүүл бүс болгож байж, малаа эрүүлжүүлж байж одоо экспортод гаргадаг юм байна. Эрүүл бүс гээд зүгээр зарлачихгүй, эрүүл бүсийг бол байгалийн тогтоц болон одоо бусад хэсгээр нь бол бүр хамаалж байж эрүүл бүс гардаг. Харин сүүлийн үед технологи гараад 3 метрт шонтой байдаг байсан бол бүр 10 метр ч шонтой, тэгээд хоёрхон ширхэг гар утас татдаг, 12 вольт түүхий ган утас татдаг ийм хамгаалалтын зурвас гаргадаг болсон байна лээ. Энийг бол бид нар бас Франц явж байхдаа л сүүлийн 2 жил гарсан гэдгийг бас биеэрээ бас харлаа. Тэр үзэсгэлэнд оролцож байхдаа.

Ер нь бид нар яг тэгэхээр олон улсын жишигийн дагуу эрүүл бүсийг



байгуулах ёстой, байгуулна. Төв гол замууд дээр нь мал эмнэлэг, хорио цээрийн одоо байцаагч ажиллана, пункт гарна, эрүүл бүс рүү хамаагүй гаднаас мал зөвшөөрөлгүй оруулахгүй. Бид нар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульдаа ч гэсэн бас чангатгаж, Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар одоо арга хэмжээ авах зүйл заалтыг оруулахгүй бол болохгүй юм байна лээ. Ялангуяа улс орнууд оруулдаг юм байна. Урагвай гэхэд бол хэрэв эрүүл бүс рүү зөвшөөрөлгүй мал оруулбал эдийн засгийн гэмт хэрэг гэж үзэж одоо эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг юм байна лээ. Тэгэхээр бид нар эрүүд нь ч байна уу, зөрчил нь ч байна уу, ямар ч байсан дураараа эрүүл бүс рүү хамаагүй мал ингэж оруулбал бас хариуцлага хүлээдэг тогтолцоо, тогтолцоог хуульдаа оруулж өгнө.

Эрүүл бүс бий болгож байж, тэнд одоо тарилга туулга, вакцин бүгдийг бол яг графикийн дагуу хийж байж вакцинтай эрүүл бүс болгоно. Мөн цаашидаа бол 2 жилээс цаашаа бол вакцингүй эрүүл бүс хүртэл болох ийм боломжтой. Эрүүл бүс болгож байж бид нар тэр махаа үнэ цэнтэй зарж чадна. Тэрнээс биш яг өнөөдрийн энэ амьдаар гаргаж байгаа, дулааны аргаар ч гэсэн гаргаж байгаа энэ байдал бол бас арга ядсан л экспорт гэж хэлэх байна. Манай ХХААХҮЯ бол энэ 3 бүс дээр эрүүл бүс болгох ажлыг бол гол зорилго, ажлынхаа нэг болгон ажиллаж байна. Баруун 3 аймаг, Увс, Ховд, Баян-Өлгий аймаг. Мөн хойд талдаа Хөвсгөл нуурын баруун талын Хөвсгөлийн 6 сум, Булган, Тэшиг, Ханхын болон Тэшигийн боомттой, Халх гол сум гээд дандаа боомт бүхий газарт газруудтай газар, эрүүл бүс бол байгуулдаг ийм олон улсын жишигтэй.

Ялангуяа Халх голд бол тэр өтгөн өндөр өвсийг нь ашиглаж бүр 100 мянган гад 100 мянган үхрийн аж ахуй байгуулах ийм зорилт тавин, эрүүл хамгаалалтай бүс байгуулахаар ингэж ажиллаж

байгаа гэдгийг бас хэлье. Энийг ажил хэрэг болгоно.

Хоёрт нь малчдын орлогын талаар сая өөрөө хэллээ. Үнэхээр энэ махны үнэ буурахаар малчдын орлого одоо буурч байгаа. Махны үнэ энэ зун экспортод мах гараагүйг мэдэж байгаа, бас энэ хаврын гэнэтийн, одоо дулааны аргаар боловсруулсан мах бол гарч байсан явдлыг бол зогсоосонтой их бас холбоотой гэдгийг бас хэлье. Саяхан 7 хоногийн өмнөөс л одоо гарч эхлээд байна дулааны аргаар боловсруулсан мах. Ер нь одоо энэ 11 сар бол мах бэлтгэлийн хамгийн оргил үе байдаг. Оны эцсийн байдлаар бол гадагшаа экспортод гаргах махны тоо хэмжээ бол гарна. Тэрнээс биш одоо нэг 3000 ч юм уу, 6000-аар бол тогтохгүй гэдгийг бас хэлье. Үнэ цэнийн хувьд бол үнэхээр 1000 малтай, 500 малтай айл болгон өөр өөрийн орлоготой байгаа.

Гэхдээ мал, махны үнэ хямдарсан үед мэдээж дагаад бол малчдын амьдрал хэцүү болж байгааг бол хэн хүнгүй мэдэж байгаа. Тэгэхээр цаашидаа бид нар бол одоо малчдаа байнгын тогтвортой орлоготой, мах нь борлодог болгоё гэвэл түрүүний хэлдгээр эрүүл бүс байгуулж, эндээсээ бол малчдаа байнгын орлоготой махаа борлуулах ийм боломжийг хангах ёстой юм гэдгийг бас хэлье. Тэрнээс биш одоо манай мах амттай, олон төрлийн өвс иддэг, эко гэж хэлээд нэмэргүй гэдгийг бол үнэхээр олон улсын олон улстай харилцах бүх л үед бол хар л даа. ОХУ ч гэсэн сая 3Г газар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болорчулуун гишүүн дуустал хариулъя.

**Х.Болорчулуун:** Махаа экспортод гаргахад маш их хүнд сурталтай, олон газраас стандарт, Худалдаа аж үйлдвэрийн танхим, мэргэжлийн хяналт, гааль, мал эмнэлэг гээд 6, 7 газраас одоо зөвшөөрөл авдаг байсан. Энд бол яг бид нар тооцоод ярихад маш олон өдөр 2 сар маш урт хугацаа зарцуулахаар ийм

тооцоо гарч байсан. Ингээд ер нь энийг цомхон болгох, хүнд сурталгүй болгох ийм цахимд оруулах ийм ажил ажил хийхээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Шаардлагагүй газраас бол заавал тийм зөвшөөрөл авах ямар ч хэрэггүй. Энийг цаашидаа бол Мэргэжлийн хяналтын байгууллага одоо 1 сарын 1-нээс ХХААХҮЯ-ны харьяанд яг харьяаллын дагуу хяналтынх нь одоо газрууд ирнэ. Ингэснээрээ бол ер нь олон газраас одоо хүнд суртал гаргаж экспорт гаргадаг биш, богино хугацаанд экспортын бичиг баримтыг бүрдүүлдэг, гаргах зөвшөөрөл олгодог ийм нөхцөл бүрдэнэ гэдгийг бас хэлье.

Тэр арьс шир боловсруулах үйлдвэрийг бол Дарханы арьс ширний үйлдвэрийг энэ дөрвөн, 4 сая сая бог, 400 мянган үхрийн арьс буюу 4.4 сая, одоо нийт арьс боловсруулах үйлдвэр байгуулахаар техник эдийн засаг, зураг төсөв нь бол үндсэндээ дуусаж байна. Тэгээд ирэх хавраас бол ажлыг нь эхэлнэ гэсэн ийм байдалтай ажиллаж байгаа. Энэ дээр бол бас та бүхэн мэдэж байгаа нэг хувийн хэвшлийнхэн, төрийнхөн гээд энэ чинь яг үнэндээ цэвэр хувь тэр хувийн хэвшлийнхэн гэдэг нь бол цэвэр хувийн хэвшлийнхэн биш. Дархан-Уул аймгийн орон, Дархан-Уул аймгийн оролцоотой 15 хувьтай ийм компани байсан. Эд нар бол зөвхөн дэд бүтэц, цэвэрлэх байгууламж хийх байсан шүү. Тэгээд энэ бол цаашидаа бас явахааргүй болсон. Төрийн өмчит компани бол өнгөрсөн жил бол байгуулаад ингээд ажил нь бол явагдаж байгаа гэж бас хэлье. Ямар ч байсан бид нар одоо бэлэнчилж, түүхий эд, арьс ширээ гадагшаа гаргадаг байсан. 2 жилийн ковидын хаалт хаагдаад, хил хаагдахад л арьс ширний үнэ навс унаад хямдарсныг мэдэж байгаа. Тэгэхээр үндэсний үйлдвэрлэл гэдэг бол зайлиггүй чухал юм гэдгийг бас эндээс бол харж болно. Энэ арьс ширний яг одоо барууны тэргүүний техник технологи бүхий үйлдвэр ашиглалтад орсноороо энэ арьс ширний үнэ тогтвортой байх, үнэд хүрэх ийм боломж бүрдэх юм гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Өнөөдөр би уул нь бид нар их чухал асуудлыг ярьж байна л даа. ХХААХҮЯ нэлээн урт нэртэй яам байна. Гэхдээ энд чинь одоо нэлээн олон асуудал нэг дор ороод ирж байна л даа. Зарим миний асуух асуултыг уул нь Ерөнхий сайд байж байгаад хариулчихвал зүгээр л юм байгаа юм. Тэгээд одоо ямар учир шалтгаантай юм, тэгээд тэр болгоныг нь яриад байлтай биш. Цаг хугацаа бага байна.

Тэгээд энэ яамнаас ажил явуулж байгаа, энэ ЗГ-аас явуулж байгаа ажил нөгөө нэг нэгдэл гэдэг айл нэг л биш ээ л гэдэг шиг л ийм л байна л даа. Нэгдүгээрт сайд шинэхэн ажлаа авсан, та бол хууль тогтоогч, Их Хурлын гишүүн, одоо бас ЗГ-ын гишүүн, бас сайд. Уул нь одоо бид нар энэ 2 ажлыг давхар хийж болохгүй гээд л 19 оны Үндсэн хуулиар өөрчилсөн юм. Тэгээд ахиад л эргээд л дээл нөмрүүлчихээд л дээ. Тэр Үндсэн хуулийг яачхаад. Яг одоо тэгээд давуу тал юу байна вэ? Ингээд сайдаар ажиллаж байхад чинь, сул тал нь юу юм байна вэ? Энэ талаар бас ажил төрөлд нэмэртэй байдаг юм байна уу, нэмэргүй байдаг юм байна уу? Энэ талаар бас нэг сонсчихъё.

Нөгөө талаар бол ер нь одоо нэг малчдаа л ад үзчихсэн, ажил хийж байгаа хүмүүсээ л нэг цааш нь яасан иймэрхүү л юм бид нар одоо энэ дундаас яриад байна л даа. Одоо өдий хүртэл энэ зэрэгтэй авч явж байгаа Монгол Улсыг энэ хэдэн малчид шүү, бэлчээрийн МАА шүү. Харин энэ бодлого буруу яваад байна. Энэ бодлого дээр бол нэг их л анхаарч, зөв сайн ажилламаар байгаа юм. Нөгөө л ярьдаг юмаа ярьсан, ийм л одоо цаг хугацаа үрсэн ийм л асуудал болчих гээд байна уу. 180000 малчин өрх өнөөдөр мал маллаж байна, 70 сая малыг. Ер нь Монгол Улсын хэмжээнд одоо хэдэн сая мал байх ёстой юм,

бэлчээрийн МАА-н даац нь ямар юм, энэ малчин өрх нэг малчин айл хэд хэчнээн мал маллахад болох юм, тийм тооцоо судалгаа байна уу?

Нөгөө талаар бол энэ малаас гарч байгаа энэ түүхий эд энэ бүх юм бол ямар ч үнэгүй болсон. Уул нь одоо энийг үнэтэй цэнтэй байлгаж, малчдын орлогыг нэмэгдүүлэх энэ ажил бол та нарын нэн тэргүүнд байх ёстой. Энэний нэг илэрхийлэл нь бол өнөөдөр одоо хаана сайгүй л энэ малын арьс шир, энэ гэдэс цувдай, толгой шир энэ бүх юм ингээд хэвтэж байна шүү дээ. Ямар ч үнэ цэнгүй. Уул нь одоо хэдэн мянган жилийн энэ одоо МАА, манай малчдын Монголчуудын үе олон жилийн авч явсан энэ зүйл маань амьсгаанаас бусдыг нь ашигладаг ийм л зүйл байсан шүү дээ. Энийг яагаад алдагдуулчихав? Тэгээд одоо малчдын одоо амьдрал нь ямар байна вэ? Өнөөдөр гэхэд түрүүчээсээ ярьж байна, дизель түли чинь 4000 болчихлоо. Энэ чинь одоо яах юм бэ гэх мэтчилэнгийн ийм зүйлүүд байна. Энэ цаг хугацаа яваад байх шиг байна.

Би бас нөгөө юу газар тариаланг яримаар байна? Газар тариалан дээр бол нэлээн хэд үр тариагаа авч байгаа юм байна. Гэхдээ жил болгон л одоо нөгөө шар шороон шуурга гээд л явдаг. Нөгөө үржил шимтэй хөрс маань салхинд хийсээд явчихдаг. Маш нимгэн, эмзэг гэж байгаа манай Монголын хөрс бол. Газар тариалан эрхлэхэд тохиромж нь ямар байдаг юм бэ? Тэгээд та сая ярилаа. 4 сараас нааш одоо дэлхийн зах зээл дээр, ялангуяа Оросын Улс Холбооны улсын зах зээл дээр гурил, үр тарианы үнэ хямдарчихсан байна, тэрийг нь оруулахгүй гэж хэлж байх шиг байна. Үгүй ээ, энэ аль алийг нь бодолцохгүй бол бас хэрэглэгчид гэж байна. Энийг бас тооцоолж ажиллах ёстой. Чанарын шаардлага хангасан буудайгаа авч чадаж байгаа юу, үгүй юу? Тэгээд үнэ тогтворжуулах гээд баахан мөнгө төгрөг гаргасан. Тэгээд өнөөдөр сав гурил бол хөдөө орон нутагт 100000

гараад явчихлаа. Цаашаа одоо ямар хэд хүрэхийг бол та л мэдэж байгаа байх тийм. Цагаан сараар одоо ямар үнэтэй гурил идэх вэ Монголчууд? Тэрэн дээр одоо ямар тооцоо байна вэ?

Нөгөө талаар бол энэ вакцин гэдэг асуудал байна. Энэ бол одоо мафийн системд шилжсэн, маш чанаргүй муу вакцин, малд өвчин тусахаар албаар тарааж байна уу гэсэн хэвлэл мэдээллээр ийм юм явж байгаа.

**Г.Занданшатар:** Болохгүй асуулт, үг. Үгүй ээ, хэн хариулах вэ? 5 минутаар явсан байна. Хэн хариулах вэ? Хаянгаагийн Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Та ажлаа аваад авсан. Сайд, гишүүн цуг хийх давуу тал юу байна гэж байна. Яах вэ, миний хувьд бол бас өөрөө агроном мэргэжилтэй, бас Гунгаадорж гуайгаас хойш 30 жилийн дараа агроном мэргэжилтэй хүн ХАА-н сайдаар томилогдож байгаа юм байна лээ. Давуу тал нь бол яах вэ, миний хувьд сүүлийн 3 жил Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажилласан. Тийм учраас энэ салбарт байгаа бугшсан болон проблемтой асуудлыг бол одоо мэднэ. Гаднаас ороод ирж байгаа хүмүүстэй адилгүй. Сул тал нь гэвэл бас мэдээж гишүүн сайд хийхэд бол тэлээ хурга шиг ажиллана, хуралдаандаа суух ажил гарна, ЗГ-ын ажлууд давхардана. Тэгээд энэ талдаа бол сул талтай гэж хэлэх байна.

Арьс шир үнэгүй үнэгүйдэж байна гэж байна. Үнэхээр арьс шир үнэгүйдэж байгаа нэг шалтгаан бол би түрүүнд хэлсэн. Ковидын 2, 3 жилийн хугацаанд гадагшаа хил хаахад л үндэсний үйлдвэрлэл байхгүй болохоор навс унаж байгаа байхгүй юу. Бид нэг дотоодын үйлдвэрлэл тогтвортой ажилладаг бол ингэж унахгүй л дээ. Тэгээд бид ямар ч байсан хувийнхантай хоршсон ч байсан, төр нь ч ажиллуулсан, арьс ширний үйлдвэрийг бол одоо барьж байгуулах

ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Ялангуяа Италийн Элчин сайд хэдхэн хоногийн өмнө уулзаад, энэ арьс ширний үйлдвэрээ та нар байгуулна шүү, бас асуудал үүсгээд маргаан дээдээд явж байна гэдгийг бас хэлж байна. Энэ бол танайд хэрэгтэйгээс гадна манайд хэрэгтэй байна Итали улсад. Яагаад гэвэл ОХУ-аас арьс ширээ авдаг байсан, энэ хаагдаад манай үйлдвэрүүд сул зогсож байна гэдгийг бас хэлж байна. Үнэхээр манай арьс энэ Сибирийн хүйтэн газрын арьс бол үнэхээр чанартай, хамгийн чанартай байдаг юм байна.

Тэгэхээр эрэлт хэрэгцээ бол маш өндөр байгаа. Ер нь нэг 300 орчим тэрбумаар арьс ширний үйлдвэрийг бол байгуулчихна. Энэ бол бараг 1, 2 жилийн борлуулалтын л ханалах мөнгө л дөө. Ингэж байж үндэсний үйлдвэрлэл, бас барууны технологиор одоо ажиллаж байж хөгжиж байж арьс ширний үнэ бол хэвийн тогтвортой байх юм гэдгийг бас хэлье. Одоо үүний төлөө бас ажиллана. Яах вэ, тэр Сангийн сайд энэ тэр бол бараг баталгаа гаргахгүй маргахгүй л гэж байна лээ. Гэхдээ энэ асуудалыг бол зайлшгүй явуулах ёстой гэдэг байр суурьтай байгаа гэдгийг хэлье. Ганц Сангийн сайд ч мэдэхгүй байх энэ ЗГ-ын хурлаар орох ёстой орно. Тэр Сангийн сайд дангаараа нэг бухимдлаа илэрхийлсэн маягтай тэгж яриад байх шаардлагагүй л байх л даа.

Газар, газар тариалан тийм улаан буудай бол ерөнхийдөө үндсэндээ жилийн хэрэгцээний улаан буудай хангахаар ийм ургацын баланс гарч байна. 391 буюу 400000 тонн улаан буудай авч байна. Чанар дээр бол бас асуудал бас гардаг, гардаг. Жилийн жилд гарч байдаг. Энэ жил ч гэсэн бас гарч байна. Гэхдээ ер нь бид нар бол үндэсний үйлдвэрлэл, дотоодын газар тариалангаа дэмжих үүднээс аль болохоороо гаднаас авахгүй, ямар ч байсан хавар хүртэл авахгүй. Үүнийгээ бол гурилын үйлдвэрийнхэн ч хэлсэн. Та нар бор шар гэхгүй дотоодын улаан буудайгаа одоо худалдаж ав гэдэг

бас чиглэлийг өгөөд, үйлдвэрүүд бол 3, 4 дүгээр зэргийн будааг хүртэл одоо голж шилэхгүй авч байгаа гэдгийг хэлье. Үнэ тогтворжуулах гээд нэг тогтоол гаргасан боловч үнэ тогтворжуулах гэж угаасаа тэр нэр нь ч бас буруу тавигдсан л даа. Өнөөдрийг хүртэл гурилын үйлдвэрүүд тэр хөнгөлөлттэй зээл 3 хувьтай гэсэн болиод, 6 хувьтай болж байна гэсэн тэр зээлийг аваагүй байгаа гэдгийг хэлье.

Тэр вакцины талаар муу вакцин гэж урьд өмнө хэдэн жилийн өмнө муу ямар вакцин хийж байсныг янз бүрийн хэл яриа гардаг л байсан. Тэгэхдээ одоо бол ОХУ-ын Владимерын биокомбинат үйлдвэрийн гэж одоо хамгийн номер нэг үйлдвэр, 900 хүнтэй ажиллагсадтай ийм улсын үйлдвэрээс вакцинаа сүүлийн 2 жил авч байгаа. Вакцин дээр бол одоо чанар дээр бол асуудал байхгүй. Тэр нөгөө вакцины асуудлыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нэг минут байхгүй, энэ 5 минутаар үг, асуулт хамт явж байгаа. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** 16 оноос хойш энэ ХХААХУ-ийн энэ салбарууд бол үндсэндээ дампуурсан. Ямар ч бодлогогүй. Энэний цаана олон мянган өрх, олон мянган ААН, олон мянган хүн бол байнга хохирсоор, ядуурсаар ирсэн. Тэгээд одоо та ажлаа аваад удаагүй байна, танд одоо бүх Монголчууд итгэл найдварын харцаар харж байна. Тэгээд бугшсан энэ одоо хэцүү зүйлүүдээс богино хугацаанд гараасай гэж ингэж хүсэж байна.

Нэгдүгээр асуулт. Саяхан Газрын ерөнхий хууль Их Хурлаар хэлэлцэхээр өргөн баригдаад байгаа юм. Энд ерөөсөө ХАА, хөнгөн үйлдвэр, хүнсний чиглэлийн гол асуудал бол суурь нь газар. Энэтэй холбоотой асуудлууд ерөөсөө Газрын хуульд тусаагүй байна. Нөгөө бэлчээрийн асуудал. Нөгөө өвөлжөө, хаваржааны асуудал. Нөгөө хилийн цэсийн асуудал, нөгөө отор нүүдлийн асуудал, нөгөө хөв цөөрмийн асуудал огт байхгүй байгаа.



Газрын хууль бол газрын хууль биш, газар дээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн эрх зүйн орчныг сайжруулах, тэднүүдийг амь амьжиргаанд нөлөөлөх л хууль. Тийм учраас таны бодлогод энэ Газрын ерөнхий хууль дээр энэ ХААЯ, бүр одоо тэр эрүүл бүс гээд л ярьж байна. Бүр онцгойлон ажлын хэсэгт нь, хэлэлцүүлэгт нь оролцохгүй бол энд одоо Газрын ерөнхий хууль гардаг. Энд одоо ХАА-н 188000 өрх, нөгөө хүнсний, нөгөө хөнгөн үйлдвэрийн салбарын асуудлууд бол огт орхигдсон байна лээ шүү гэдгийг хэлэх юм. Тэгээд энэ дээр одоо ямар асуудал хийх гэж байна вэ гэдгийг хэлэх гэсэн юм.

Дээр нь арьс ширний үйлдвэрийг ярингуут л нэг Дарханы аж үйлдвэрийн парк гээд ярьдаг юм. Ийм биш шүү дээ. 16 онд нөхдүүд нэг боодол бохь барьчхаад л боодол бохь нэг арьсаар одоо боодол бохь ч авч чадахгүй байна гээд байсан. Тэрнээс хойш чинь 7, 8 жил болчихлоо шүү дээ. Ковид чинь сүүлийн л 2 жилийн л асуудал шүү дээ. Ингээд 7, 8 жил хөдөөгийн ард иргэдийн 4 цагийн улиралд үйл тамаа барсан махыг нь үнэгүйдүүлнэ, дээр нь арьсийг нь хаяулна, байгаль орчин бузарлана, энэ асуудлаа шийдээч. Шийдэж болно шүү дээ. 90-ээд оны дундуур 2000-аад оны эхээр одоо арьс ширийг чинь гаргадаг л байсан шүү дээ. Амь амьжиргаагаа 2 нэхий, 10 нэхийг аваад гарахад зохицуулж болдог л байсан шүү дээ. Энийг одоо зохицуулаач дээ, ойрын хугацаанд.

Дээр нь энэ нөөцийн асуудалд ерөөсөө ХААЯ оролцож болохгүй. Тэр хүмүүсээ өлсгөнө үү, жагсаана уу энэ одоо ер нь махны үнийг өсгөх ёстой. Дээр нь одоо тэр нийтэд нь өсгөж байж энэ амь амьжиргаагаа ХАА-н салбараа босгож ирэхгүй бол. Сая Цогтгэрэл гишүүн хэлж байна шүү дээ. Мянган малтай, дээр нь зуун бодтой хүмүүс 4 цагийн эргэлтэд хаврын хавсарга, зуны халуун, отор нүүдэл, өвлийн тэсгэм хүйтнийг давчхаад хорь хүрэхгүй сая төгрөгийн орлого олж байна гэж. Ингээж

боолын хөдөлмөрөөр бусдыг тэжээх юм уу? Тийм учраас амьдралын түвшин доогуур, үнэхээр тэр тэтгэвэр тэтгэмжтэй хүмүүстэй тэр нөөцийн махаараа татаас өгдөг юм уу, яадаг юм гэхээс зэрэг энэ дарга сайд нар, энэ компани нүүсийн эзэд гадагшаа явахаараа өтөн чинээ махыг 30, 40 мянгаар авчхаад, энд ирээд 4 цагийн эргэлтэд үйл тамаа барсан малчдын махыг болохоор 8000-аар авахгүй гэж ингэж боолын хөдөлмөр, Монгол хүнийг, Монгол МАА-г доромжилдгоо болих хэрэгтэй. Тэгэхээр үнийг чөлөөл.

Ингээд одоо төв орон газрынхаа ядарч зүдэрч байгаа, тэтгэвэр тэтгэмжтэй, групптэй байгаа хүмүүсээ даралтны эмийг яадаг вэ та бүхэн. Мааш өндөр үнэтэй юм бичээд өгдөг. Тэгээд яг авах болохоор нь хямдруулаад өгч болдог шүү дээ. Тэрэн шиг энгийн орлоготой хүмүүс яахаараа заавал ийм одоо хямд төсөр мах авна гэж ингэж загнаж байдаг юм бэ гэдэг. Тэгэхээр энийг бол одоо мааш яаралтай шийдэх хэрэгтэй байна. Тэгээд ингээд тавхан минутад одоо ийм том бараг Монгол орны тавиас дээш хувийг яаж байгаа хөнгөн үйлдвэр, ХАА, хүнсний үйлдвэрийн талаар тавхан минутад асуулт асууна гэсэн ойлголт байхгүй л дээ. Гол одоо энэ 3 зүйлийг анхаарах хэрэгтэй.

Тэгээд одоо тэр шүлхийн асуудал. Хятадууд шүлхийтэй махаа бүгдийг хэрэгцээнд оруулдаг байсан. Манайхан хэдэн зуун тэрбумаар нь хөдөө аваачиж булдаг юм. Төрийн албан хаагчдыг чирэгдүүлдэг. Дээр нь тэмээн дээр ямаа, ямаан дээр янгианы гарц гаргадаг. Энэ асуудлаа болих хэрэгтэй, хэрэгцээнд оруулдаг хэрэгтэй. Махныхаа экспортыг мааш яаралтай хийгээч дээ. 80000 тонн мах экспортолж байсан, одоо гуравхан мянган тонн гээд ярьж байгаа, ичмээр биш шүү. Нөгөө 180000 тонн мах экспортолно гээд амлаад байсан зүйлүүд юу болсон бэ? Эдгээр зүйл дээр бас.../минут дуусав/



**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Хаянгаагийн Болорчулуун сайд асуултад хариулъя.

**Х.Болорчулуун:** Та мэргэжлийн сайдын хувьд бол энэ салбарт бугшсан асуудлыг бол сэтгэлээсээ бас өөрчилж ажиллаарай гэж итгэж байна гэж байна баярлалаа. Түүний төлөө ажиллах болно.

Энэ Газрын хууль дээр бол одоо ХАА-н салбарын асуудал сайн орж ирээгүй байна гэж бас өөрөө хэлсэн байна. Ер нь Газрын хуульд манай яам санал өгсөн өмнө нь. Дөнгөж 50 хувийг нь авсан, 50 хувийг нь аваагүй юм байна лээ. Түүнээс гадна Бэлчээрийн хууль бол бас Улсын Их Хурал дээр өргөн баригдаад дуншаад явж байгаа. Тэрэн дээр бол бас ХАА-н бэлчээр, мал, малчинтай холбоотой асуудал бас нэлээн яригдана гэдгийг бас хэлье. Гэхдээ нэг л зүйл манайд бол нүүдлийн МАА-тай, бэлчээрийг бол хувьчилж бол хэрхэвч бол болохгүй юм. Хэтэрхий өмчлүүлж болохгүй гэдгийг бас ийм байр суурьтай байгааг бас хэлье.

Дарханы арьс ширний цогцолбор ярьдаг гээд. Одоо бид нар арьс ширээ боловсруулъя гэвэл ярихаас өөр аргагүй. Одоо нэг хувийн хэвшлийнхэн маань бол 100 гаруй мянган үхрийн арьс, арьс 2, 3 сая хоньны арьс л боловсруулж байна одоогийн байдлаар. Ер нь одоо би түрүүнд хэлсэн. Арьс ширний эрэлт хэрэгцээ бол одоо эко талаасаа гээд бүтээгдэхүүн хийх талаасаа маш их эрэлт хэрэгцээтэй сүүлийн үед болсон юм байна лээ. Италийнхан, Туркийнхэн энэ асуудлыг ярьж байна. Маргааш Туркийн арьс ширний юу хэдэн бизнесмен яг арьс ширээ яасан 3, 4 бизнесменууд ирнэ. Бид ганцхан энийг төрөөр хийх биш, аль болохоор бас төрөөс бага мөнгө зарцуулж, бас хамтарч гаднынхантай хүртэл одоо энэ арьс ширний үйлдвэр явуулах арга замыг бас эрэлхийлж байгаа гэдгийг бас хэлье.

Энэ махны экспорт түрүүнд 16 онд л гарсан, тэрнээс хойш гараагүй гэж. 18 онд 70000 тонн мах гарсан шүлхийний өмнө жил. Ер нь махны үнийг одоо яг хатуу ХХААЯ бол барьсан юм бол байхгүй шүү дээ. Зах зээлийнхээ жамаар байгаа. Харин тэр нэг нөөцийн махыг авдаг байдал бол бас тодорхой хэмжээний бас нэг үлгэр жишээ болчихоод байгаа юм л даа. Юу тэр нөөцийн махыг бол ирэх жил бол ямар ч байсан ХХААЯ энийг бэлдэхгүй гэдгийг хэлье. Бид бол ХХААЯ-ны хувьд бол бодлогын үйлдвэрлэл, махны үйлдвэрлэгч төлөөлж ажиллахаас биш энэ нийслэл хотоо хүн амаа махтай байлгах нь бол нийслэлийн удирдлага, угаасаа маркетингийн сүлжээ дэлгүүр бүх юм нь нийслэлтэй байдаг болохоор энийг бол нийслэл хариуцах нь бол зөв зүй зүйтэй юм гэсэн асуудлыг ярьж, ярьж байгаа ЗГ дээр.

Үгүй ээ, боловсруулаагүй тодорхой хэмжээний арьсууд гарч байгаа тийм. Асуулт асуусан гишүүддээ баярлалаа. Бас сайхан зөвлөгөө өглөө, ташуур өгч, ажилд маань та бүхэндээ баярлалаа гэж хэлье.

**Г.Занданшатар:** Шинэ дэгийн дагуу одоо гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо шинэ дэгийн дагуу буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу D-парламент хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулаад иргэдээс ирсэн саналуудыг ЗГ-ын гишүүдээс бүлгийг төлөөлж гишүүд асууж, асуулт асууж, хариулт авч мэтгэлцэнэ. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ ЗГ-ын гишүүнээс асуулт асууна. Асуулт асуух зөвшөөрөл өгч байна, ингээд үргэлжлээд 20 минут асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ. Шууд микрофон асаад явна. Асуулт, хариулт 20 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** 20 минут гэсэн тийм ээ?

**Г.Занданшатар:** Асуулт, хариулт нийлээд 20 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ингээд Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуулт гэж байгаа юм. Энэ дээр ингээд 9 асуулт, 2 нь бол бас өөр чиглэлээр асуусан ийм 11 асуулт байна. Ингээд нэгдүгээр асуулт махны экспорт Буюнжаргал гэдэг иргэн асуусан байна. Махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа вэ гэж байна. Та ерөнхийдөө бас саяын ерөнхий зүйлийг нь хариулчихлаа. Энэ дээр бас тодруулж хариулж өгөөч гэж, ямар яг тодорхой, ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Миний би дээрээс нь бас мэтгэлцэнэ гэдэг утгаар нь бол хэдэн нэг зүйл нэмье. Адуу адууны мах гаргах асуудал ер нь ямаршуу хэлбэртэй байж байгаа вэ? Бид нар чинь одоо адуугаа энэ чинь бас нэг 5 гаруй сая болчихсон байгаа байх. Тэгээд та өөрөө Дорнод аймгийн хүн мэдэж байгаа. Дорнод, Сүхбаатар, Хэнтий чиглэл рүү бүх адуу чинь ер нь бараг л гараад явчихлаа. Адууны мах адууг адуу эргэлтэд оруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал маань нэлээн хойрог байгаа шүү дээ. Тэгэхээр адууны мах гаргах асуудал ямаршуу байгаа вэ гэсэн асуулт юу нэмж, асууя?

**Г.Занданшатар:** Болорчулуун сайд цаг чинь яваад байгаа шүү. Бат-Эрдэнэ гишүүн асууж байх юм уу? Таны мкрофон бас асаалттай байх шиг байна.

**Х.Болорчулуун:** Махны экспортын чиглэлээр ямар арга хэмжээ авч байна вэ? Ер нь холын ерөнхий стратеги бол би түрүүнд хэлсэн. Бид олон улсын жишгийн дагуу одоо эрүүл

бүс байгуулж л гаргах одоо гол арга. Ингэж байж бид нар олон улсын жишгийн дагуу махаа үнэтэй өгнө. Тогтвортой махны борлуулалт хийх ийм боломж бүрдэх юм. Ялангуяа одоо долоохон хоногийн өмнө Узбекийн ХАА-н сайдтай ярьсан. ХАА-н Узбек бол мах авах маш сонирхолтой байна, хамтарсан cooperative аж ахуй байгуулъя. Танай баруун аймгуудаар эрүүл бүс дээр чинь ажиллаж, мах авъя. 12 сардаа гэхэд л одоо ажлын хэсэг ирж ажиллуулъя гэдэг асуудал тавьж байна. Улс орнууд ер нь их сонирхож байна. Вьетнам руу гарч байна, Узбек, Казахстан руу гарч байна. Арабын Имрат улс руу гарч байна. Ялангуяа адууны мах бол Казахстан улс руу бас нэлээн гарлаа. Энэ чинь хэдэн.

**Г.Занданшатар:** Болохгүй ээ, дэгээ унш.

**Х.Болорчулуун:** Гэхдээ энэ дээр махны экспорт дээр бол бас хэдэн нэг юм баримтлахгүй бол нэг цонхны бодлого баримтлахгүй бол манай бизнесмен бол нэг нэгнийхээ дундуур бол бас доогуур үнийг нь одоо унагаж үнээ үнэгүйдүүлж байна. Казахсан руу гэхэд адууны мах анх 3 доллар 30 центээр гэрээ хийж байсан. Сүүлдээ нэг нэгийнхээ доогуур бас 2 доллар 30 цент болох болж байх жишээтэй. Тэгэхээр энд юу вэ гэхээр ХХААЯ, Махны холбоо хамтарч үнийн зөв бодлого, хамгийн бага үнийн доод үнийг хүртэл баримтлах ийм нэг цонхны бодлого бол зайлиггүй хэрэгтэй бол харуулж байгаа юм. Энэ чиглэлээр бас ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Шууд нээлттэй байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байхгүй байна. Товчхон, товчхон хариулаад явъя, мэтгэлцэх шаардлагатай байна. Та бид 2 Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хамт ажиллаад та даргаар ажиллаад ингээд бас санал нэгдээд явж байсан. Хийх ажлууд маш их байгаа. Махны экспорт дээр тодорхой

асуултууд, тодорхой зүйлүүдийг хариулмаар байна. Энэ хүмүүс чинь одоо юмнуудыг чинь бэлдээд, хамгийн гол асуудал махны экспорттой холбоотой асуудалд аль хэдийн ийм, ийм ажлуудыг хийх ёстой, ийм экспортыг тийшээгээ ярьсан, яриагүй бол яриагүй, ярьсан бол ярьсан, тэгээд шаардлагатай бол одоо ийм хэлэлцээрүүдийг хийх ёстой эд нар гээд ийм тодорхой зүйлүүдийг сонсох гээд байна шүү дээ. Энэ хүмүүс чинь хүртэл түрүүнээс хойш энийг л сонсох гээд байгаа байхгүй юу даа.

Одоо энэ махны эрүүл мэндтэй холбоотой нэг асуудал байгаа байгаа. Энэ Алтанцэцэг гэдэг хүнээс шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах өвчин ихээр гарах боллоо. Малын өвчинтэй тэмцэх талаар мэдээлэл авъя гэж байгаа байхгүй юу. Малын өвчинтэй. Нэг зүйл байгаа, эрүүл бүс бий болгож байж бид нар малаа экспортолно гэж одоо энэ асуудал яг таныг ирснээс хойш гарч ирж байна. Маш олон удаа миний хувьд бол давтсан шүү. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль боловсруулах үеэс эхлээд эрүүл бүс бий болгож байж бид нар цаашаа явдаг юм байна гэж ярьсан. Одоо энд сууж байгаа энэ Батчулуун дарга чинь энийг маш дээдийн дээдээр мэдэх ёстой. Өнөөдрийг хүртэл хийгээгүй. Та харин сайд болж байгаад орж ирж энэ асуудлыг дэвшүүлж байх шиг байна.

Хоёрдугаарт, эрүүл бүсээ хийх асуудлуудаа маш тодорхой товчхон хэлчихмээр байна. Одоо жишээ нь Булган аймгийн хувьд бол тэр гол устай нь, уул устай нь холбож байгаад, хашиж байгаад тийшээгээ хэн ч ордоггүй болгоод уулын цаана тэр ой хөвчтэй нь холбоотой нэг талаасаа хашаад, нэг талаасаа голоор нь хашиж байгаад эгээд тэр нэг ганцхан гүүр, хоёрхон гүүрэн дээр нь бүр маш том юу хийж байгаад юу билээ, нөгөө хяналтын пост эд нар хийж байгаад ингээд бид нар эрүүл бүсийг бий болгох ёстой шүү дээ.

Тэр одоо Дорнодын тэр том тал дээр би одоо яаж хийхийг нь сайн мэдэхгүй байна. Баруун аймгууд эрүүл гэж байна, одоо өнөөдөр эрүүл бүс байхгүй болсон шүү. Сая одоо энэ хэлж байгаа 20 аймгийн 200 суманд гарсан 200 биш ээ, 300 суманд чинь 330 сумууд чинь бүгдээрээ гарчихсан. Энэ шүлхий чинь. Одоо бид нар хувьсгал хийж байж энэ дээр гарах ёстой. Тийм болохоор энэ саяын хэлсэн Алтанцэцэг гэдэг хүний асуулт дээр дахиад нэг нэмэхэд нэгдүгээрт эрүүл бүсээ яг тодорхой нэг хэлж өгөөч. Яг ямаршуу байдлаар хийх гэж байгаа юм бэ? Тэр тор татах юм уу, яах юм бэ? Торных нь мөнгө нь шийдэгдсэн юм уу, яасан юм бэ? Тэрнийг нь хэлж өгөөч.

Хоёрдугаарт, 2027 он хүртэл тактик боловсруулсан гэж байна. Ямар тактик юм бэ? Тэгээд дараа нь дахиад нэмье.

**Х.Болорчулуун:** Зөв. Таны хэлдгээр яг л олон улсын жишгээр эрүүл бүс байгуулж одоо бид нар ажиллана. Баруун 3 аймаг гэхэд тэр Увсын хойд талаас Ховдын урд хүртэл одоо хамгаалалтын зурвасад одоо эрүүл бүс байгуулна. Гэхдээ энэ дээр бол Хан хөхийн нуруу, Алтайн нурууны яг өндөрлөг хэсгээр бол тэр хамгаалалтын зурвас бол татахгүй. Бас 200 гаруй километр нь нийт 900 километр, 200 гаруй километр нь бол усан одоо Завхан гол байдаг юм байна лээ усан хил. Тэгэхээр ерөнхийдөө бол 900 километрээс 400 орчим километр бол хамгаалалтын зурвас татах шаардлагатай. Энэ дээр бол хуучин бол бүр хашаа татдаг байсан юм байна лээ олон улс. Харин сүүлийн 2, 3 жил бол тэр нэг одоо 2 зурвас бүхий 12 вольтоор ажилладаг ийм хамгаалалтын одоо зурвас хашаатай, хашаа ч гэж одоо зүгээр хамгаалалт юм даа 12 вольт. Үхэр мал ойртоход бол энэ ганц, 2 цохиулаад ойртохоо больдог. Энэ бол бас хялбар, бүр шон нь гэхэд 10 метрт ингэж тавигддаг. Үнийн хувьд бол та бүхэн

мэдэж байгаа. Төсөв дээр шинэ юм байхгүй байгаа.

Гэхдээ бид нар экспорт, экспортыг дэмжих төсөл, мал амьтны эрүүл мэндийг малын нөгөө 2 дахь нь эдийн засгийн эргэлтийг дэмжих энэ 2 төслөөсөө бас тодорхой хэмжээний мөнгө одоо нэг шаардахгүй гэсэн зүйлээс бол татаж авч энд оруулахаар төлөвлөөд байгаа. Энэ 10 гаруй тэрбумыг бол ер нь ерөнхийд нь төлөвлөж гаргагчаад байгаа. Мөн гол замууд дээр тавих тэр эрүүл бүсийн хяналтын постыг бол он дотроо үндсэндээ постын зураг төсвийг нь гаргаад, тендерийг нь бол зарлана гэдгийг бас хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр 2027 он хүртэл мал эрүүлжүүлэх тактик гээд айхтар том тактик яриад байх юм. Энэ чинь нь ямар учиртай юм, бүр тодорхой товчхон хариулаадаг даа.

**Г.Занданшатар:** 82.

**Д.Батчулуун:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. ДМАЭМБ-ын газрын амьтны эрүүл мэндийн кодекс дээр тухайн одоо олон улсын худалдаанд нөлөөлдөг, экспортод одоо шууд нөлөөлдөг өвчнүүдтэй тэмцэх арга аргачлал бол бүрэн заагдсан байдаг. Энэ дагуу бид нар шүлхий өвчнийг богино хугацаанд хумж авахын тулд 2022, 2023 онд хэрэгжүүлэх богино хугацааны тактикийг боловсруулсан. Энэ дагуу шүлхий өвчинд мэдрэг зарим мал амьтныг сонгож, ингэж масс дархлаажуулалтын ажил хийгдэж байна. Мал эмнэлгийн ерөнхий газраас 2025 онд гэхэд Монгол Улсын зарим бүс нутгийг шүлхий өвчнөөс эрүүл тайван гэдэг статусыг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн яам байгууллагаас авахаар ингэж зорилт, томоохон зорилт тавин ажиллаж ажиллаж байна.

Ер нь 2027 он гэхэд ганц шүлхий биш, бог малын мялзан, шүлхий, үхрийн

арьс товруутах, бусад олон улсын худалдаанд буюу экспортод нөлөөлдөг өвчнөөс одоо бүрэн эрүүлжих, эрүүл гэдэг тайван байдлыг одоо баталгаажуулсан ийм статусыг авахаар бид нар дархлаажуулалт, судалгаа шинжилгээ, оношилгооны ийм цогц стратегийг бид нар сая Мал эмнэлгийн ерөнхий газрын эрдэмтдийн зөвлөлөөр 4 сард бол хэлэлцэж баталгаажуулсан. Энэнийхээ хүрээнд бас тодорхой хэмжээний дархлаажуулах ажил мөн экспорт, импортолж авахаар хүсэлт гаргаж байгаа улс орнуудтай мал эмнэлгийн олон улсын гэрчилгээ тохирох, худалдааны нөхцөлөө тохирох энэ ажлуудыг үе шаттай 2027 он хүртэл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас өнөөдрийг хүртэл маш их олон хэмжээний бичиг баримт одоо юу гэдэг юм шаардлага ирсэн. Өнөөдрийг хүртэл бид нар харин муутгачихсан байхгүй юу Батчулуун даргаа. Муутгачихсан. Таны наад стратеги дотор чинь дан цаас байна. Энэ цаасыг чинь бид нар бэлдээд л яваад байгаа шүү дээ. Цаасаар наад мал чинь эрүүлжихгүй байхгүй юу даа. Болорчулуун сайдаа би хэлье, хатуу хэлье, эндээ хувьсгал хий. Энэ хүмүүсийнхээ асуудлуудыг одоо эргэж хар, хагас цэрэгжсэн маягтай ийм байдалтай байхаар наад малаа эрүүлжүүлэхээс биш зүгээр ингээд цаас боловсруулаад, наад цаас боловсруулах асуудлууд чинь би зөндөө сонссон шүү дээ. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хийж байх явцад зөндөө сонсчихсон наадхыг чинь. Уучлаарай, би жаахан нервтээд байна. Цаас боловсруулснаар наадах чинь стратеги болоод мал чинь эрүүлжүүлэхгүй. Одоо энэ Туваан гишүүн бас сууж байна. Бид нар таны үед Байгаль орчны байнгын хороо дээр ажиллаж байхдаа ажлын хэсэг гаргаж байгаад Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд байгаад тогтоол гаргасан шүү дээ.



Энэ тогтоолоор 3 жилийн хугацаанд 23, 24, 25 гээд 3 жил, жилд 2 удаа вакцинжуулах ёстой. Вакцинжуулж байж наадах чинь эрүүл бүс бий болгож байж, вакцинжуулж байж наад мал чинь эрүүлжихээс биш цаас боловсруулснаар эрүүлжихгүй байхгүй юу. Жилд 2 удаа вакцинжуулна гэсэн асуудал чинь хаана явж байгаа юм бэ? Тэрэнд гарсан мөнгө чинь хаана явж байна вэ? Энэ дээр нэг хариулж өгөөч.

**Г.Занданшатар:** Ассан байна.

**Х.Болорчулуун:** Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг үнэн. Үнэхээр тарилга туулга вакциныг бид нар цаг тухайд нь хийж байж одоо эрүүл бүс, эрүүл мал бий болгоно. Ялангуяа сүүлийн жилүүдэд бол бас энэ вакцины мөнгийг хагас дутуу тавьснаас тарилга туулга хугацаандаа хийгдэхгүй, үүнээс болж бол бас юу өвчин шүлхий тарсан бас гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Харин 4 жилийн хугацаанд энэ хүнсний хувьсгал, энэ хүнсний аюулгүй байдал, хангамжийг дээшлүүлэх 36 дугаар тогтоолынхоо хүрээнд зуун дөчин тэрбумыг одоо зөвхөн мал эрүүлжүүлэхэд тавьсан байгаа. Малын вакцин эм тарилга дээр. Ирэх 23 онд гэхэд дөчин нэгэн тэрбумыг вакцин дээр тавьсан байгаа. Тэгэхээр бол вакцин, тарилга, туулганы хувьд бол одоо бол асуудалгүй бас төсөв дээр тавьж байгаа, байгаа болохоор бид нар графикайн дагуу бол энийг бол хийгээд, малаа эрүүлжүүлэх нэг үндэс болно гэдгийг бас хэлье.

Ер нь бид нар зүгээр эрүүл бүс болгоно гээд баруун 7 аймгаа эрүүл аймаг болгоно гээд 6 жил явж байж сүүлдээ шүлхий гараад эрүүл бүс болгоогүй. Энэ угаасаа тэгж хамгаалалтын зурвас татаагүй, хорио цээрийн пост ажиллуулаагүй, эрүүл бүс байгуулна ч гэж байдаггүй юм байна лээ. Тэрийг ч одоо Франц төвтэй мал, амьтны эрүүл мэндийн байгууллага бол хэлж байна лээ. Анх удаа харин та нар эрүүл бүсийг бас

байгуулна гэж амбицтай санал дэвшүүлж байна, баяр хүргэе гэж хэлж байлаа. Бид энэний талаар эрүүл бүсийг байгуулж, цаашаа малаа эрүүлжүүлж, экспортод гаргахын төлөө бол тууштай ажиллана, бүтээлч ажлыг хийх болно гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болорчулуун сайдад баярлалаа. Яг ингэж ажиллах ёстой байх шүү. Одоо ер нь бол энэ боловсон хүчнийхээ холбоотой асуудлуудыг бас эргэж хараарай. Хагас цэрэгжсэн байдлаар, тэгээд эрүүл бүс бий болж, тэнд хяналтыг нь нэлээн хатуухан барьж байж бид нар малаа эрүүлжүүлэхээс биш зүгээр толгойг нь илээд одоо ийм байдлаар ажиллаад бол хэзээ ч наадах чинь мал эрүүл болохгүй шүү.

Хоёрдугаарт тэр 40 хэдэн тэрбум төгрөгийн асуудал чинь бол хаанаа ч хүрэхгүй. Энэ чинь жилдээ зуун дөчөөд 140 рүү гэж бид нар тооцоо гаргасан шүү дээ. 140 байж бид нар чинь 2 удаа бараг л дал, далаар вакцинжуулна гэсэн. Дээрээс нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал байгаа. Тэрэн дээр одоо бид үүрэг хүлээчихсэн шүү дээ, хэдүүлээ бүгдээрээ үүрэг хүлээсэн. Энэ вакцинжуулалттай холбоотой асуудал, энэ эрүүл бүстэй холбоотой асуудал болон энэ хяналттай холбоотой асуудал, бүсчилсэн байдлаар хийх асуудал бүгдээрээ байж бид нар эрүүл болно гэж.

Нэг асуулт байх шиг байна. Энэ Наянтай гэдэг хүн гурилын нь их өсөж байна, энэ талаар хариулт авъя гэж. Энэ дээр бас нэг иргэдийн хариулт болохоор бас хараад сууж байгаа байх. Энэ дээр та бүхэн нэг хариулаач.

Хоёрдугаар асуулт хүнс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ зуун хувь Лхагвасүрэн гэдэг хүн асуусан байна шүү, хангах боломж хэзээнээс бий болох вэ, энэ чиглэлийн бизнес эрхлэгчид



төрөөс үзүүлэх ямар дэмжлэгүүд байгаа вэ гэж байна. Энэ дэмжлэг дотор би тэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан санаачилга, Улсын Их Хурлаас гарсан 36 дугаар тогтоолтой холбоотой асуудал дээр жаахан нэмж тодруулга өгөөч гэж хэлж байна. Өөрөөр хэлбэл, бид нар дотоодынхоо үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний хангамжаа нэмэгдүүлэхэд 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэе гэсэн байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр нэлээн акцент өгч хариулт өгөөч гэж хүсэж байна.

**Х.Болорчулуун:** Хүнсний ногооны хувьд бол энэ жилийн хувьд өнгөрсөн жилээс 15 хувь өссөн, ургац хураалт. Тэгэхээр 70 хувьд хүрсэн байгаа, нийт дотоодын хангамжийн. Бид ойрын 2 жил бол зуун хувьд хүргэнэ гэсэн итгэл төгс байна. Та бид нар Байнгын хороогоороо дэмжээд гол 8 нэр төрлийн хүнсний ногооны импортын татварыг 15 хувь байхыг 30 хувьд хүргэсэн байгаа. Харамсалтай харин Ковидын нөхцөл байдлаас шалтгаалаад ЗГ энийг хэрэгжүүлээгүй, түдгэлзүүлээд ирсэн. 23 оны 1 сарын 1-нээс одоо хэрэгжинэ. Ер нь одоо намрын чуулганаар хүнсний ногоо гэлтгүй бусад хийж байгаа, хийж чадах одоо хүнс, хүнсний зүйлээ одоо импортын татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх ийм хуулийн одоо Их Хурлаар оруулахаар ингэж бас ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Гурилын үнийн хувьд бол тэр одоо улаан буудайн үнэ одоо 50-55 хувь өссөн. Улаан буудайнд ордог түлш шатахуун гэхэд одоо 40 хувь, ургамал хамгааллын бодис, бордоо гээд 80-100 хувь өсчихсөн, ийм учраас яалт ч үгүй улаан буудайн үнэ өссөн юм. Тэгэхдээ гурил будааны үнэ бол одоо холоо байг, хөрс зэргэлдээ хамгийн их одоо тариалдаг, дэлхий дээр тариалдаг, ОХУ-ын буудай гурилын үнээс өндөр биш байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ импортын татварыг нэмнэ гэж та

сүүлийн үед нэлээн хатуухан шиг дуугарч байгаа. Энэ бол маш зүйтэй алхам болж байгаа юм. Ингээж байж бид нар дотоодынхоо үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хамгаалах, тэд нарыгаа хөл дээр босгох үйл ажиллагаа явагдана. Энэ хүмүүс маань бас энийгээ харж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр энэ наад бодлогоо маш одоо хэрэгжүүлэх тал дээр нь анхаарч ажиллаарай, зөв зүйтэй бодлого шүү гэж бас танд хэлье.

Хоёрдугаарт, энэ аливаа зүйл дэмжлэггүйгээр явахгүй гэдгийг та мэдэж байгаа байх, санал нэг байдаг гэж би ойлгож байгаа юм. Би зүгээр лоозон бариад ч байдаг юм уу, хөгжүүлэх ёстой гэж яваад энд одоо кармандаа хов хоосон, эсвэл одоо тоног төхөөрөмж, техник нөхцөл бололцоо нь байхгүй ийм хүмүүсийг мянга шахаад бид нар бол энэ үйлдвэрлэлийг хийж чадахгүй. Тэгэхээр дэмжлэг бол бас одоо зайлшгүй байх ёстой байдаг юм. Энд Батмөнх гэдэг хүн хэлж байна. Хүнс, хүнсний ногооны үйлдвэрлэлээ асуусан байна, үйлдвэрлэлд шаардлагатай шинэ техник тоног төхөөрөмж худалдан авсан иргэн, ААН-үүдэд үнийн дүнг нь тавь хүртэл татаасаар дэмжих боломж байгаа юу гээд. Энэ байгаа талаар бид нар бас урьд өмнө нь ер нь бол ярьсан шүү дээ. Тэгээд энийг улс хийгээд ч ирсэн байгаа.

Нөгөөтээгүүр энэ хүнсний хангамжтай холбоотой асуудал дээр одоо хоосон хүмүүсийг юу гэдэг юм, боломж бололцоогүй, тариаланч ногоочдоо бид нар бол мянга шахаад болоод нэмэргүй гээд би сая хэллээ. Тэгэхээр боломжийг нь нэгдэж өгч байж, нэмж өгч байж бид нар одоо энэ үйлдвэрлэгчдээ дэмжих ийм ганц гарцыг бол бий болгох ёстой юм. Тэгэхээр энэ дээр хариулт өгөөч гэж, баярлалаа.

**Х.Болорчулуун:** Манай улс чинь өргөн уудам нутагтай, бас хүнсний ногоогоо бол дотоодоосоо хангах бүрэн боломжтой, урд өмнө ч бас хангаж байсан. Бодлого алдагдсанаас ингээд

хангаж чадахгүй өнөөдрийг бас тасалчихсан гэдгийг хэн хэнгүй ойлгож байгаа. Ер нь тэгэхээр Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай энэ тогтоол та бид нар гаргасан. Манай байнгын хороогоор бол одоо хэлэлцэж, ялангуяа энэ бүх одоо асуудал нь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Минут дууссан уу? Дэгээр нэмж болохгүй юм байна л даа. Одоо Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан ЗГ-ын гишүүнээс асуулт асууж хариулт авна.

**Ц.Туваан:** Тэгээд энэ Их Хурал дээр, бас энэ Их Хурлын дэгийн тухай хууль шинэ дэг орж ирж байна, бас мэтгэлцэх байдлаар хариулт авдаг, энэ одоо их зөв сайн дэг орж иржээ тэгээд. Энэ хугацаанд одоо бас асуултууд адилхан, намуудын бүлгүүдээс бас давхцадаг юм байна. Давхцаагүй асуудлууд дээр хариулт авъя.

Энэ юун дээр эрүүл вакцингүй бүс гээд энийгээ яг хаана юм бэ? Тэнд, тэнд, тэнд гээд яг тодорчихсон юм байгаа юм уу? Яг хэзээ хийчих вэ, хөрөнгө нь байгаа юу? Юунаас.

**Г.Занданшатар:** 83. 83 дээр. Х.Болорчулуун гишүүн 83.

**Ц.Болорчулуун:** Тэгэхээр эрүүл бүс байгуулах талаар 2 долоо хоногийн өмнө Монгол Улсын ЗГ-ын хуралдаанд бол танилцуулж, тэмдэглэл гаргасан. Одоо бол өнөөдөр ингээд яг ЗГ-т хүргүүлчихсэн байгаа, өчигдрийн байдлаар. Эрүүл хүнсээ байгуулах ЗГ-ын тогтоол шийдвэр яг хаана байгуулах юм гээд газруудаа тодорхой болгосон. Тухайлбал баруун талдаа Увс, Баян-Өлгий, Ховд гэсэн 3 аймгийн аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан эрүүл бүсийг байгуулъя гэж байгаа. Төвийн бүсдээ Эгийн, Хөвсгөл нуураас эх явж байгаа Эгийн голоор байгалийн байраар болгож, Хөвсгөлийн одоо 6 сум, Булганы Тэшиг сумыг хамарсан, тэгээд

энэ хойд улсынхаа хил рүү ингээж хашсан байдлаар эрүүл бүс байгуулъя гэж байгаа. Зүүн талдаа бол Дорнод аймгийн Халхгол сумыг бол бүхэлд нь эрүүл бүс байгуулъя. Дотор нь бол эхний ээлжид 120 хүртэл мянган га талбайд талбайг ашигласан эрүүл аж ахуйг эрүүл бүс бүхий аж ахуй байгуулъя гэсэн ийм байдлаар ЗГ-ын хуралдааны тогтоол оруулахаар ЗГ-т хүргүүлсэн байж байгаа. ЗГ-ын хуралдаан шийдвэр гаргахаар.

Энэ үүнтэй холбоотой тодорхой хэмжээний зардлууд гарахаар байгаа юм. Тухайлбал энэ түрүүчийн сайдын хэлдэг, одоо тэр хамгаалалтын зоныг барьж байгуулахад тодорхой хэмжээний зардал гарна. Эрүүл мал эмнэлгийн пунктууд барихад зардал гарна, тэгээд энэ зардлуудыг бол бид нар энэ яамныхаа хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийнхээ зарим санхүүжилтүүдийг ийшээ өөрчлөх хэлбэрээр чиглэлийнх нь дагуу өөрчлөх хэлбэрээр зохион байгуулахаар ингээж одоо энэ эрхийг нь бол сайдад өгөхөөр ЗГ-ын тогтоолд тусгасан байж байгаа.

**Ц.Туваан:** Энэ квот байхгүй гээд байгаа махны. Ганихан одоо энэ үхрийн махан дээр л гарчихсан. Тэгээд квотгүй гээд байгаа ч гэсэн энэ чинь дурын ААН шууд одоо юу, одоо махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд ч гэсэн мах гаргах боломжгүй шүү дээ. Нөгөө экспортлож байгаа орныхоо одоо мал, мал эмнэлэг, хорио цээрийн магадлан итгэмжлэл хянан баталгаажуулах ийм асуудлын ар дээр ярьдаг шүү дээ. Хятадаас гэхэд 10 гаруй байгаа байх. Одоо яг хэд хэчнээн улсын, хэдэн хэчнээн улс яг энэ хянан баталгаажилтаа хийчихсэн манайхаас аль, аль улс дээр хэд хэдэн компани өгчихсөн байна вэ? Ажлын хэсгээс.

**Г.Занданшатар:** 82.

**Д.Батчулуун:** Туваан гишүүний асуултад хариулъя. Экспортлохын мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох талаар мал эмнэлгийн санамж бичиг, гэрээ протоколыг нийтдээ 32 оронтой байгуулсан байна. Өнөөдрийн байдлаар Тайланд, Малайз, булангийн орнуудтай мал эмнэлгийн олон улсын гэрчилгээ нөхцөлөө тохирох ажлууд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар экспортын зөвшөөрөл авсан ААН нэгжүүдийн тоо 96 ААН-үүд явж байна. Цаашидаа экспортлох хүсэлтэй ААН-үүдийн хүсэлтийг тухайн импортлох орнуудын мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, мөн ОХУ-аас улсаар дамжин өнгөрөх транзитийн зөвшөөрлийг авах ажлуудыг ОХУ-ын мал эмнэлгийн байгууллагад бол тухайн үед нь хүргүүлээд явж байна. Цаашидаа энэ дундад азийн орнууд, булангийн орнууд руу мах экспортлох ийм хүсэлтэй ААН-үүд, мөн цаад талаасаа Монгол Улсаас мал, малын гаралтай бүтээгдэхүүн импортолж явъя гэсэн хүсэлтэй компаниудын тоо бас тодорхой хэмжээгээр нэмэгдээд явж байгаа.

**Ц.Туваан:** Ажлын хэсэг дараа нь дахиж нэмж хариулаарай, энэ буруу яриад байна. Жишээлбэл, одоо БНХАУ улсаас ирээд одоо би бол 12 гэж сонссон. Яг тэрэн шиг Хятад 12, хамгийн сүүлд Вьетнам ирсэн 4 үйлдвэр орсон гээд ийм хариулт авах гэсэн юм. Ингээд тойруулаад цаг ороод байх юм, энийг дахиад нэмж хариулаарай.

Хоёрдугаарт нь энэ улаан буудай өнгөрсөн жил түрүүн сайдын үгэнд бас гарна лээ. Өнгөрсөн хугацаанд ер нь бол энэ дотоодын тариаланчдаа бол алаад хаячихсан шүү дээ. 240000 тонн улаан буудай гаалийн мэдээ би авсан. Тэгээд энэний чинь гор нь 2 жил дамнаад гарахгүй шүү дээ, одоо нөгөө борлуулалт гээд л. Тэгээд л нөгөө хуучин чинь бас гурилын үйлдвэрүүд олон байгаа, өрсөлдөөд хүчин чадал ихтэй өрсөлдөөд авдаг байсан. Одоо сүүлийн 2 жил бол

хөөрхий нөгөө тариаланчид нь гуйж борлуулдаг болчихлоо. Үлдэгдэл маш ихтэй болчихлоо. Тэгэхээр энэ одоо улаан буудай ч гэсэн, тэгээд л баланс их өндөр тогтдог 441.4 тонн мянган тонн гээд ингээд урьдчилсан баланс гарсан гэсэн. Хураан авсан нь 334.7 гээд. Одоо аль хэзээний л нэг 305000 тонн улаан буудай байвал улсын хэрэгцээ гэсэн. Одоо хүн ам ч бас нэлээн өсчихсөн, өсөө байлгүй дээ Тэгээд энэ дээр бас түрүүн гишүүд бас хэлээд байсан. Тэгэхээр энэ баланс яагаад ингэж уначихав? Гагийн ургацын дундаж бүр 12 руу орчихсон шүү дээ. Энэ дээр, энэ 2 дээр хариулт гялс. Энэ газар тариалангийн газрын дарга.

**Х.Болорчулуун:** Хэн Есөн-Эрдэнэ.

**Г.Занданшатар:** 85.

**Д.Есөн-Эрдэнэ:** Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Ургац хураалтын урьдчилсан дүнгээр улаан буудай 391 мянган 90000 тонныг хураагаад байна. Энийгээ ингээд аваад үзэх юм бол энэ дотоод дотоодын хэрэгцээгээ хангах хэмжээний ургац хурааж аваад байна. нэ баланс 8 дугаар сард ургацын ерөнхий төлөв балансыг болохоор 8 сарын 25 нд гаргадаг. Энэ төлөвөөрөө бол нэг 400 гаруй мянган тонн улаан буудай хурааж авна гэсэн ийм ерөнхий төлөв гарсан. Нэгжийн ургац бол үндсэндээ нэг 13 центнер гагаар гарсан. Энэ ургац хураалтын явцад бол энэ байгаль цаг уурын бас хүйтрэл, бороо цас орсон, энэ нь бол бас ургац хураалтад ингээд сөргөөр нөлөөлсөн. Мал, амьтан одоо талбайд орсон зэрэг байдлаас шалтгаад нэгжийн ургац бол бас тодорхой хэмжээгээр буурсан. Яг ургац хураалт, тийм 1 центнер, 12 центнер болж буурсан байгаа. Тэгээд энэтэй холбоотойгоор бол бас улаан буудайн ургац тодорхой хэмжээгээр буураад байгаа. Баланс бол одоо нэг биологийнхоо нөхцөлөөр байгаль, цаг уурын тааламжтай нөхцөл байвал төдий хэмжээний хурааж авна

гэдэг ингэж 8 сарын 25-нд гаргадаг ийм тоон үзүүлэлт байгаа.

**Ц.Туваан:** Товчхон шүү, минут яваад байна.

**Г.Занданишатар:** 83.

**Ц.Болорчулуун:** Тэгэхээр БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох бүртгэлтэй дулааны аргаар гэж дотроо бас дулаан, төхөөрөх гэж 2 янз байгаад байгаа. Тэгээд дулааны аргаар боловсруулсан мах, мах, махан бүтээгдэхүүн экспортлох 19 ААН. Төхөөрөхийн зөвшөөрөлтэй 10, адууны мах экспортлох 9 гэсэн ийм зөвшөөрөлтэй ААН-үүд байна. Тэгэхээр энэ зөвшөөрөлтэй ААН-үүд дээр одоо гарна гэсэн гэж ойлгож болно. ОХУ-д Монгол Улсаас ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох 31, адууны мах экспортлох 30, тэгээд бэлэн бүтээгдэхүүн лаазалсан, одоо бүтээгдэхүүн үйлдвэрлэх 10 ААН байгаа. Бүгд Найрамдах Казахстан улсад 3 ААН, Бүгд найрамдах Узбекистан улсад 6 ААН мах экспортлох зөвшөөрлийг авсан байгаа.

**Ц.Туваан:** Энэ одоо яах вэ, ингээд бас бага ч гэсэн ингээд хураагаад авчихсан, намар бас сайхан ивээлээ. Тэгээд энэ тариаланчид дээр чинь борлуулагдаагүй улаан буудайн үлдэгдэл маш их байна, маш их байна. Өөрсдийнхөө үтрэм дээр ч байна, шороон дээр ч тавьчихсан байна, хүний элеватор юманд хийчихсэн ч байна, ингээд борлуулалт нь байхгүй. Маш их, гурилын үйлдвэрүүд бол маш их гол шилжэвч байгаа. Энэ дээр бас нэг нэмэр болохуйц нэг шийдвэрийг бас бид нар одоо амьдрал дээр байгаа асуудлыг тавьж байгаа нь энэ 100000 тонн нөөцийн улаан буудай. Энэний худалдан авалт ер нь явж байгаа юм уу? Энэийг бас бид нар тодорхой хэмжээний дотоодын энэ хүнд нөхцөлтэй байгаа энэ үед улс байна даа нэг 100000 хүртэл тонн улаан буудайн ядаж нөөцтэй байа гэж

оруулсан. Дээрээс нь энэ ААН-үүдийнхээ худалдан авалтыг бас дэмжье гэж бодсон. Энэ яг ямар шаттай, ямар явцтай явж байна вэ?

**Х.Болорчулуун:** ААН-үүдийн 60, 70 мянга орчим тонн улаан буудай одоогоор яг борлогдоогүй байна гэсэн мэдээтэй байна. Тэгэхээр би түрүүнд хэлсэн. Дотоодын улаан буудай бүр борлогдож дуустал ер нь л тодорхой хэмжээгээр дутагдвал хавар хавраас багахан хэмжээгээр намар хүртэлх нэг багахан зэрэг одоо гаднаас оруулах асуудал ярихаас биш, гаднаас улаан буудай оруулж, урдынхтай адилхан бол дотоодын тариаланчдаа бол хүнд байдалд оруулахгүй гэдгийг бас хэлье. Тэгэхдээ энэ буудайнууд бол бас ингээд хатаалт, сэргэлт энэ тэр хийж байгаад ер нь борлогдож байгаа. Өдөр өдрөөр мэдээ бол нэмэгдэж байгаа гэдгийг бас хэлье. Нөгөө юу асуулаа.

Юу Хөдөө аж ахуйг дэмжих сан одоо 25000 тонн аваад байна. Одоо таваарт. Үрэнд бол 3.5 мянган тонныг аваад байна. Нийт 18.5 мянга, 28.5 мянган тонн, 30 шахуу юу яалаа. Түүнээс гадна өнгөрсөн жилийн улаан буудайн үлдэгдэл 30000 тонн, үндсэндээ 60000 тонны ийм нөөцтэй болоод байгаа гэдгийг бас хэлье. Энэнээс илүү бас нэмэгдүүлэх бас хүсэлгүй байна. Яагаад гэвэл гурилын үйлдвэрүүд аваг, тэрнээс биш одоо заавал одоо Хөдөө аж ахуйг дэмжих сан авчхаад, эргээд гурилын үйлдвэртээ л борлуулна шүү дээ. Их өндөр, илүү өндөр центнер авсан бол тэр 100000-д нь хүргэх ийм боломж байсан.

**Ц.Туваан:** Хүнсний ногоон дээр нэг та хэдийн тайланг ингээд харж байгаа юм. Танилцуулгыг. 2021 онд 9.4 мянган гад тариад 118.6 мянган тонн тонныг хүлээж авч, 2022 онд 11.1 мянга буюу ойролцоогоор 2 орчим мянга гагаар тариалалт нэмэгдсэн байна. Тэгээд хураан авсан ургацын чинь хэмжээ 125.8. Өнгөрсөн оныхоос нэг 7 орчим мянга



тонноор л нэмэгдсэн. Тэгээд нөгөө нэг 70 хувь гээд байгаа энэ тоо чинь нэг жоохон эцэслэгдээгүй байх. Тэгэхдээ л ер нь энэ нөгөө урамшуулалтай холбогдож энэ асуудал нэмэгдэж байгаа л гээд бодоод байсан чинь яг цаасан дээрээ бол ондоо байна шүү. Хоёрдугаарт энэ юу, энэ дээр нэг хариулт өгчихөөрэй.

Хоёрдугаарт, энэ хүнсний ногооны урамшуулал дээр ирэх жилийн төсөв дээр 8 гаруй тэрбум төгрөг сая улсын төсөв дээр батлаад өгчихсөн. Энэний журам одоо би энэ намрын ногоон өдрүүдээр үзэсгэлэнгээр хөдөөний ногоочдоос бас таараад асуугаад. Дээрээс нь энэ Төв аймгийн ногоочдоос таараад асууж байхаар энэ журмын чинь сурталчилгаа ерөөсөө явсан юм уу? Нэг хүн ирсэн гэсэн, мэдэхгүй гээд. Тэгээд энэ бид нар энэ бодлого гаргаад, шийдвэр гаргаад яваад байдаг. Улсын төсөв дээр урамшууллын мөнгийг нь тавьж өгөөд байдаг. Энийг чинь авах юм ногоочин байгаа юу, яг судалгаатай ийм одоо зүйл байна уу? Яг хэдэн ногоочин, хэдэн тэрбум төгрөгийн урамшууллыг авахаар байна вэ?

**Х.Болорчулуун:** Ногоочид уу, хүнсний ногоог бас Улсын Их Хурлаас шийдвэр гаргаж, хүнсний ногооны үрийг наян хувийн хөнгөлөлттэй энд олгож байгаа бол ногоочдыг бас тарих, гагаа нэмэгдүүлэх эрмэлзлийг улам нэмэгдүүлсэн. Түүнээс гадна одоо энэ жилийн хувьд бол бас тонн тутам 100000 тоннууд урамшуулал олгохоор улаан буудайтай адилхан өгөхөөр болсон нь бол ногоочдыг бол бас маш их урмыг бол дэмжсэн явдал болсон. Гэхдээ одоогоор бол тэр урамшуулал өгөх асуудал байхгүй. 1 сарын 1-нээс 23 оны төсөв дээр суугдсан байгаа урамшууллыг 9 тэрбум орчмыг. Одоо хүнсний ногоочдод олгоно гэдгийг хэлье. Нийт 6.5 мянган ногоочид урамшуулал хүртэнэ. Гэхдээ энэ дээр бол хийсвэр дүн нэг их айхтар байхгүй гэж би үзэж үзэх байна. Яагаад гэвэл бүгдийг нь цахимд оруулж байгаа. Одоо манай ХХААХҮЯ-ны

мэргэжилтнүүд бүх аймагт явж, ажилласан. Аймаг, сумаар. Ингээд цахимд оруулж байгаа. Нийт хураан нэг ААН-ийн хураан авсан хүнсий ногооных нь 70 хувьд нь л одоо урамшуулал ойлгож байгаа. Тэгэхээр бол нэг их хийсвэр одоо илүү нөгөө урамшуулал өгчихнө гэсэн асуудал байхгүй л гэдгийг хэлье.

**Ц.Туваан:** Түрүүн энэ Д-парламентаар бас ирсэн хүмүүсийн асуултуудаас нэлээнийг нь Ж.Бат-Эрдэнэ гишүүн бас асуучихсан. Энэ дотор энэ асуучихсан байгаад байна. Энэ дотор Оюунсоёмбо гэдэг хүн ХАА-н салбар юм л бол татаас авдгаа болимоор юм. Хүмүүст мөнгө тараахгүйгээр яаж шийдэх вэ? Хувийн хэвшил, хоршоололд боломж олгох орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ талаар ямар бодлого байна гэж асуусан байна.

**Х.Болорчулуун:** ХАА бол одоо манайх битгий хэл бүр тааламжтай, энэ хөгжиж байгаа улс орнуудад татаас олгодог. Америк, Канад хүртэл. Татаасгүй ХАА хөгжинө гэж байхгүй. Хэрэв хоолоороо гаднын хараат болбол тэр улсын одоо колони боллоо л гэсэн үг ний нуугүй хэлэхэд. Франц улсыг та бүхэн мэдэж байгаа. Бид нар сая үзэсгэлэнд оролцоод, тэнд ХААЯ-ны удирдлагуудтай нь, дарга сайдтай нь уулзсан. 5 сараас эхлээд ХХААЯ-аа бүрэн эрхэт ХХААЯ гэж нэрлэсэн байна лээ. Яагаад ингэж байгаа юм гэсэн чинь манайх бол одоо ХАА-гаа дахин үйлдвэржүүлэх, дахин хөгжүүлэх, гаднаас авдаг юмаа багасгаж, дотоодоо ХАА-гаа хөгжүүлэхийн төлөө бас ажиллаж байгаа. Ингээд яамныхаа нэрийг хүртэл бас өөрчилсөн гэж хэлж байна.

Одоо би бас жишээ татаж хэлдэг. Япон, Япон гэхэд цагаан будаа өөрийнхөө газар нутаг дээр тарих нь Хятадаас авснаас 2.2 дахин үнэтэй байдаг гэж байгаа юм. Гэсэн хэдий боловч тэр ажлын байр бий болох байдал, гаднаас валютаар авах байдал,

мөн гол нь хүнсний зүйлээр гаднын хараат байхгүйн үүднээс ингэж зуун хувиар илүү ч байсан, үнэтэй ч байсан өөрийнхөө газар нутаг дээр одоо тариалдаг. Тийм учраас аливаа улс орон бол татаас ХАА-даа татаас өгч байдаг юм гэдгийг бас хэлэх байна.

**Ц.Туваан:** Татаастай бол би одоо түрүүн асуулт учраас асуусан. Сайдын санал хэлж байгаатай бол санал нэг байдаг. Өндөр хөгжилтэй орнууд хүртэл татаастай явдаг. Тэгэхээр энийг бол одоо дэмжиж байгаа. Энэ бол хоолтой хүнстэй холбоотой асуудал. Тэгтэл яагаад энэ жил улсын төсөв дээр та тэр татаас чинь нийт хэмжээгээрээ хүнсний ногооны урамшуулал гээд энэ дотор нэмэгдэж орж ирж байхад 66-г 45 болгох бодлого дээр одоо хүлээн зөвшөөрчхөв, энэ ямар юм явчлав? Ийм нэг асуулт асууя.

**Х.Болорчулуун:** Төсвийн урьдчилсан санал бол манай яамнаас бол урамшуулал татаас бол бүр 90 тэрбум байсан шүү дээ. Тэгээд өнгөрсөн жилийн үлдэгдэлтэйгээ нийлээд өөрийн чинь хэлдэг 66 үнэн нь л дээ. 90 тэрбумыг дундуур нь хуваагаад л ердөө урамшуулал, татаасыг бол 50 хувь багасгасан. Ингээд 40 хэдэн тэрбумаар Сангийн яамны тогтоосон ийм татаас урамшууллын хэмжээ байгаа гэдгийг хэлье.

**Ц.Туваан:** Дараагийн асуулт энэ Монгол Улсын Ерөнхийлөгч оруулж ирээд, Улсын Их Хурал дээр Занданшатар дарга, 76 гишүүн дэмжээд хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой энэ маш том хөтөлбөр батлаад өгсөн, төлөвлөгөөтэйгөө. Уг нь 1.7 их наяд төрөөс орох хөрөнгө оруулалт нь гээд. Энэ жил дээр бид нар 220 гаруй тэрбум төгрөг улсын төсөв дээр. Тэгээд энэ газрын дарга Болорчулуун энэ тэр гадаадын хөрөнгө оруулалтаас бараг 190 тэрбум, хадгаламжийн даатгалаас 60 тэрбум энэ тэр гээд нэг сайхан, сайхан тоонууд

харагдаад л байна. Энэ дотор нэг асуух ёстой, ярих ёстой асуудал бол энэ ХАА-н салбарыг үнэхээр бодитоор дэмжих асуудал бол энэ санхүү, хөрөнгийн дэмжлэг шүү дээ. Тэгээд энэ дээр Монголбанкнаас болохоор энэ бодлогын хүү нэмэгдүүлээд, мөнгөний хөдөлгөөнийг царцаагаад, зээл авалтыг багасгаад ингээд царцаах тал руу нь ингээд явчихсан. Банкнууд одоо зээл өгөхгүй. Өгсөн ч зургаагаас доош хувийн хүүтэй зээл өгөхгүй.

Тэгэхээр энэ төсөв дээр тавьсан 128 тэрбум төгрөг чинь өөрөө тэр хүүгийн марж буюу зөрүү төлөх мөнгө байгаа. Тэгэхээр энэ үндсэн тэр зээлэнд өгөх мөнгө чинь хаана байгаа юм бэ? Ер нь хүүгийнхээ хэмжээнээс болоод 1 их наяднаас, 1.3 их наяд төгрөг ХАА-н бүх салбарууд руу тэр төлөвлөгөөнд орсон салбаруудаар орох ёстой. Энэний мөнгөн дээр энэ Монголбанк энэ тэртэй хамтарсан бодлого байна уу? Энэ мөнгө чинь хаана байгаа юм бэ гэсэн асуулт асууя.

**Х.Болорчулуун:** Туваан гишүүн бол бас Байнгын хорооны гишүүний хувьд бас өөрөө ХАА-н талаар бол бас тоо баримт, бодлогоо сайн хэлж байна. Зөв, үнэн. Үнэхээр 36 дугаар тогтоолоор бол зөвхөн 23 онд хүүгийн хөнгөлөлтөд зөрүүнд 138 тэрбум олгосон байгаа. Энэ чинь бо 1.3-1.5 их наядыг зээл олгохтой тэнцэх, зээл олголтын хүүгийн зөрүү мөнгө л дөө. Бид бол Сангийн яаманд Засгийн газрын бонд гаргадаг ч юм уу, ийм байдлаар шийдье гэсэн яамнаас санал өгсөн боловч Сангийн яам зөвшөөрөөгүй. Одоо энэ жил бол банкны бас хяналт шалгалттай холбоотой бас нэлээн зээл хумигдсан. Ирэх жил арай өөр болно гэсэн байдлаар хандаад байна лээ.

**Г.Занданшатар:** Асуулт асууж, хариулт авч дууслаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонслоо.

*16.23 цагт*

*Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ                      Д.УЯНГА*